



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 29-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	3-4
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	5-35
<i>1.Эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүний үнэ, бүрдэл, чанарын өнөөгийн байдалд хяналт шалгалт хийх үүрэг бүхий ажлын хэсгийн тайлан, хяналт шалгалт, үнэлгээ хийсэн дүнгийн талаар мэдээлэл сонсох</i>	5-35

Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы Хянан шалгах түр хороо /Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг хянан шалгах/-ны 11 дүгээр сарын 29-ний өдөр /Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл

Хянан шалгах түр хорооны дарга Ж.Чинбүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 7 гишүүнээс 5 гишүүн хүрэлцэн ирж, 71.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 46 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Ц.Туваан;

Тасалсан: М.Оюунчимэг.

Нэг.Эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүний үнэ, бүрдэл, чанарын өнөөгийн байдалд хяналт шалгалт хийх үүрэг бүхий ажлын хэсгийн тайлан, хяналт шалгалт, үнэлгээ хийсэн дүнгийн талаар мэдээлэл сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Эрүүл мэндийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга П.Оюунцэцэг, мөн яамны Эм, эмнэлгийн хяналт зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Энхтуяа, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Бодлого, төлөвлөлтийн газрын Тусламж үйлчилгээний багц, зохицуулалтын хэлтсийн дарга Б.Баярболд, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Эм хангамжийн газрын дарга Г.Цэцэнсанаа, мөн газрын Эмийн аюулгүй байдлын тандалт судалгааны газрын дарга П.Цэцгээ, Эм хангамжийн газрын мэргэжилтэн Г.Хулан, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Ням-Эрдэнэ, мөн газрын Өрсөлдөөний зохицуулалт, зах зээлийн судалгааны газрын дарга Ч.Однасан, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах зар сурталчилгааны газрын дарга Ц.Тэрбиш, Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Мөнхханд, Хянан шалгах түр хорооны хянан шалгагч Б.Саруул, С.Саруултөгс, М.Халиунаа, Г.Чойжамц нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн ахлах зөвлөх Ч.Онончимэг, референт Ж.Лхагвасүрэн, мөн газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Д.Гэрэлт-Од нар байлцав.

Эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүний үнэ, бүрдэл, чанарын өнөөгийн байдалд хяналт шалгалт хийх үүрэг бүхий ажлын хэсгийн тайлан, хяналт шалгалт, үнэлгээ хийсэн дүнгийн талаар Эрүүл мэндийн яамны Эм, эмнэлгийн хяналт зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Энхтуяа, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын Хэрэглэгчийн эрхийг хамгаалах зар сурталчилгааны газрын дарга Ц.Тэрбиш нар мэдээлэл хийв.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа, Б.Бейсен, Д.Батлут, Ц.Сандаг-Очир нарын тавьсан асуултад Эрүүл мэндийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга П.Оюунцэцэг, мөн яамны Эм, эмнэлгийн хяналт зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Энхтуяа, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын Хэрэглэгчийн эрхийг хамгаалах зар сурталчилгааны газрын дарга Ц.Тэрбиш нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн, Д.Батлут, Ц.Сандаг-Очир нар үг хэлэв.

Байнгын хорооны гишүүд Эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүний үнэ, бүрдэл, чанарын өнөөгийн байдалд хяналт шалгалт хийх үүрэг бүхий ажлын хэсгийн тайлан, хяналт шалгалт, үнэлгээ хийсэн дүнгийн талаар мэдээлэл сонсов.

Уг асуудлыг 12 цаг 28 минутад хэлэлцэж дуусав.

Түр хорооны дарга Ж.Чинбүрэн Хянан шалгах түр хорооны хянан шалгагч нарын ажлын явцын талаарх мэдээлэл сонсох учраас хуралдааныг хаалттай явуулах горимын санал гаргав.

Ж.Чинбүрэн: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 1

Бүгд: 5

80.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул 12 цаг 30 минутад хуралдааныг хаалттай горимд шилжүүлэв.

Нээлттэй хуралдаан 1 цаг 44 минут үргэлжилж, 7 гишүүнээс 5 гишүүн хүрэлцэн ирж, 71.4 хувийн ирцтэйгээр 12 цаг 30 минутад өндөрлөв

Тэмдэглэлтэй танилцсан:

ХЯНАН ШАЛГАХ ТҮР
ХОРООНЫ ДАРГА

Ж.ЧИНБҮРЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их засаг” танхим
10 цаг 46 минут.

ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ж.Чинбүрэн: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая аа.

Эмийн үнийн өсөлтийн шалтгаан нөхцөлийг хянан шалгах үүрэг бүхий Хянан шалгах Түр хорооны гишүүдийн ирц бүрдсэн тул Түр хорооны 23 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье ээ.

Хуралдааны ирцийг тан танилцуулъя.

Дамбын Батлут гишүүн Орхон аймаг 20 дугаар тойрог ирсэн байна. Бадарчийн Жаргалмаа гишүүн СХД 27 дугаар тойрог ирсэн байна. Цэндийн Сандаг-Очир Багануур дүүрэг 21 дүгээр тойрог ирсэн байна. Жигжидсүрэнгийн Чинбүрэн миний бие Баянзүрх дүүрэг 23 дугаар тойрог ирсэн, Буланы Бейсен гишүүн орж ирж байна гэж байна. Цэвэгдоржийн Туваан гишүүн орон нутагт томилолтоор ажиллаж байгаа юм байна. Оюунчимэг гишүүн бас орж ирэх юм байна аа. ингээд хурлаа эхэлье.

Өнөөдрийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэнэ ээ.

1.Монгол Улсын Шадар сайд, Эрүүл мэндийн сайдын 2023 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн 20-А95 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан Эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт

бүтээгдэхүүний үнэ бүрдэлд чанарын өнөөгийн байдалд хяналт шалгалт хийх үүрэг бүхий ажлын хэсгийн тайлан, хяналт шалгалт, үнэлгээ хийсэн дүнгийн талаар мэдээлэл сонсоно.

Хоёр дахь асуудал. Хянан шалгах түр хорооны тогтоолын төслийг батална. Энд бол Хянан шалгах түр хорооны зардал, хянан шалгагч, шинжээчийн ажлын хөлс төлбөрийг тогтоох тухай асуудал байгаа.

Гурав дахь асуудал. Хянан шалгагч нарын гүйцэтгэсэн ажлын явцын талаарх мэдээлэл сонсох гэсэн 3 асуудал байгаа.

Хэлэлцэх асуудлын талаар өөр саналтай гишүүд байна уу?

Хэлэлцэх асуудалдаа орёе оо.

Эхний асуудал. Монгол Улсын Шадар сайд, Эрүүл мэндийн сайдын 2023 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн дугаар бүхий хамтарсан тушаалаар батлагдсан эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүний үнэ бүрдэлд, чанарын өнөөгийн байдалд хяналт шалгалт хийх үүрэг бүхий ажлын хэсгийн тайлан, хяналт шалгалт, үнэлгээ хийсэн дүнгийн талаар мэдээллийг сонсоно.

Мэдээлэл хийх ажлын хэсгийг танилцуулъя аа.

ШӨХТГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ням-Ээрдэнэ ирсэн байна, ШӨХТГ-ын газрын Өрсөлдөөний зохицуулалт, зах зээлийн судалгааны газрын дарга Однасан, ШӨХТГ-ын Хэрэглэгчийн эрхийг хамгаалах зар сурталчилгааны газрын дарга Тэрбиш, ШӨХТГ-ын Бодлого төлөвлөлтийн газрын дарга Мөнхханд, ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Оюунцэцэг, ЭМЯ-ны Эм, эмнэлгийн хяналт, зохицуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Энхтуяа, ЭМД-ын

ерөнхий газрын Бодлого төлөвлөлтийн газрын Тусламж үйлчилгээний багц зохицуулалтын хэлтсийн дарга Баярболд, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын Эм хангамжийн газрын дарга Цэцэнсанаа, Эм эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын Эмийн аюулгүй байдлын тандалт судалгааны газрын дарга Цэцэгээ, Эм эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын Эм хангамжийн газрын мэргэжилтэн Хулан.

Ийм ажлын хэсгийн нийт 10 хүн бүгд хүрэлцэн ирсэн байна аа.

Мэдээллийг ЭМЯ-ны Эм эмнэлгийн хяналтын зохицуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Энхтуяа, ШӨХТГ-ын Хэрэглэгчийн эрхийг хамгаалах зар сурталчилгааны газрын дарга Тэрбиш нар танилцуулна аа. Хэн нь эхэлж ярих вэ? Энхтуяад микрофон 1 номерын микрофон. Энэ чинь дараад нээгдэж байгаа юу? Нэг номерын микрофон нээгээрэй.

Танилцуулгаа эхэлье.

Д.Энхтуяа: Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Тэгэхээр Шадар сайд, Эрүүл мэндийн сайдын хамтран баталсан удирдамжийн хүрээнд Шударга өрсөлдөөн хэрэглэгчдийн төлөө газар Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, Татварын Ерөнхий газар хамтраад хяналт үнэлгээ хийсэн байгаа. Тэгээд хяналт үнэлгээний дүнгийн талаар товч танилцуулъя.

Ж.Чинбүрэн: Танилцуулгын тайлан надад өгсөн. Тэрийгээ олируулаад гишүүдэд Түр хорооны гишүүдэд бүгдэд нь тарааж өгөх хэрэгтэй байна.

Танилцуулгаа явуулаарай Энхтуяа.

Д.Энхтуяа: Шадар сайд, Эрүүл мэндийн сайдын хамтаран баталсан удирдамжийн хүрээнд хяналт үнэлгээ хийсэн байгаа. Энэ яагаад хяналт үнэлгээ хийсэн юм бэ гэхээр байгууллагууд хамтаран хийсэн үйл ажиллагаа бас дан ганц хяналтаас гадна бас үнэлгээ судалгаа нэлээн хийгдсэн учраас удирдамж ингэж гарсан байгаа. Тэгээд Эм эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар Эрүүл мэндийн яам, ШӨХТГ, Татварын ерөнхий газар, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, Стандарт хэмжил зүйн газар гэсэн байгууллагуудаас төлөөлөл энэ бүрэлдэхүүнд орж 7 ажлын хэсэг болж ажилласан байгаа.

Ер нь бол хяналт үнэлгээний зорилго бол эм эмнэлгийн хэрэгслийн үнэ бүрдэлт, чанар, зохистой хэрэглээний өнөөгийн байдалд үнэлгээ хийх холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шалгалт, үнэлгээ хийх, шийдвэр гаргагчдыг нотолгоонд суурилсан мэдээллээр хангах, холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд өөрчлөлт оруулах, санал боловсруулах гэсэн гол зорилготой байсан.

Хяналт үнэлгээнд хамрагдсан байгууллагын хувьд бол 223 эмийн сан хамрагдсан. Энэ эмийн санг яаж сонгосон бэ гэхээр нийтдээ ЭМД-аар хөнгөлөлттэй эмээр үйлчилдэг. Сүүлийн 1-ээс 2 жилд хамгийн өндөр санхүүжилт авсан эмийн сангуудаас түүвэрлэж оруулсан байж байгаа. Эм ханган нийлүүлэх байгууллагын хувьд бол сүүлийн жилүүдэд хамгийн өндөр импорт хийсэн эм ханган нийлүүлэх байгууллагуудыг бас мөн сонгосон байгаа. Үйлдвэрийн хувьд болохоор зөвшөөрөлтэй үйлдвэрүүдээсээ борлуулалтаараа хамгийн өндөр үйлдвэрүүдийг сонгосон байгаа. Тэгээд аймагт ажиллаж байгаа байцаагч нар маань аймгийн нэгдсэн эмнэлгүүд Бүсийн оношилгоо, үйлчилгээний төвүүдээр бас явж хяналт үнэлгээ хийсэн байгаа.

Тэгээд хяналт үнэлгээг бол яаж хийсэн бэ гэхээр яг газар дээр нь очиж нөхцөл байдалтай танилцсан. Холбогдох баримт бичгийг үзэж шалгасан. Зарим эм хангамжийн байгууллагын болоод эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудтай ярилцлага хийсэн. Иргэдээс болоод эм хангамжийн эрүүл мэндийн байгууллагын мэргэжилтнүүдээс асуумж судалгаа авсан. Тэгээд тайландаа дүн шинжилгээ хийх байдлаар хяналт үнэлгээ хийсэн.

Эхний хамгийн гол асуудал эмийн үнэ бүрдэл шатлал бүр дээрх үнэ нэмэгдлийн талаарх асуудал байгаа. Тэгэхээр ерөнхийдээ бол бид хэд яасан бэ гэхээр нийтдээ 2022 онд манай улсад хамгийн олон тоогоор импортлогдсон 50 олон улсын нэршилтэй худалдааны нэршилээрээ 240 эмийг гаалийн үнээс жижиглэнгийн үнэ хүртэлх нэмэгдэх хувь хэмжээ нь ямар байгаа вэ гэдгийг судалж үзсэн байгаа.

Тэгэхээр энэ бол эхний үнэ буюу хэлцлийн үнэ, үйлдвэрлэгчийн үнэ нь тухайлах юм бол 100 төгрөг байхад гааль, татвар, даатгал, үйл ажиллагааны зардал гээд энэ эм ханган нийлүүлэх байгууллагууд дээр энэ зардлын 17 хувь нь нэмэгдэж байна. Эм ханган нийлүүлэх байгууллагууд дээр бас нэмэгдэл 25 хувь тэгээд эмийн сан дээрээ бол 30 хувь, иргэдийн гар дээр НӨАТ нэмэгдээд энэ нөгөө 100 төгрөгийн эм маань 209 төгрөг болж байна гэж энэ судалгаанд хамрагдсан эмүүд дээрээ харьцуулсан судалгаа хийхэд ийм дүн харагдсан байж байгаа. Тэгээд энийгээ нөгөө эм хангамжийн байгууллага гэдэгт нь эмийн сан, эм ханган нийлүүлэх байгууллага эмийн, үйлдвэр гээд ингээд нийтэд нь эм хангамжийн байгууллага гээд нэрлэдэг. Тэгээд энэ үнэ бүрдэлтийнхээ байдал, ханган нийлүүлэх байгууллага буюу бид нарын ярьдгаар бөөний төв дээрээ ямар байна вэ гээд үзсэн.

Бид нарын нөгөө саяын хэлсэн 50 олон улсын нэршилтэй 250 худалдааны нэршилтэй эм маань энэ дээр 414 байгаа. Энэ 414 нь яагаад гарч ирсэн юм бэ гэхээр энэ нөгөө нэг худалдааны нэршилтэй эмийг 2, 3 ханган нийлүүлэх импортлогдсон гэдэг байдлаар орохоор 414 эм болж байгаа юм. Тэгээд энэ дээрээс ингээд үзэхээр энэ эмээс бол ер нь бол 30 хүртэл хувиар нэмж байгаа байдал нь 78.5 хувь, 3.2 хувь нь болохоор 2-оос 4 дахин нэмж борлуулсан байна аа. Энэ судалгаанд хамрагдсан энэ эмүүдээс 7 нэрийн эм нь бол үнэ нэмэгдэлгүй байна гэсэн эм ханган нийлүүлэх дээр байгаа. Дээр нь эм ханган нийлүүлэх дээр бас Эксклусив гэрээний асуудал гэж байдаг. Энэ юу вэ гэхээр тухайн эм дээрээ тухайн ханган нийлүүлэх байгууллага л гэрээ байгуулчихсан өөр ханган нийлүүлэх байгууллага оруулж ирдэггүй эм гэсэн үг.

Тэгэхээр яг энэ судалгаанд хамрагдсан эм дотроос 54 эм нь Эксклусив гэрээтэй эм байсан. Тэгэхээр Эксклусив гэрээтэй эмийн хувьд бол 44 хувь нь бол 30 хүртэл хувиар нэмэгдэж байгаа, 8 хувь нь 2-оос 4 дахин нэмж борлуулсан байгаа. Тэгэхээр ерөнхийдөө бол энэ нөгөө хамрагдсан эмийнхээ 13 хувь нь бол эксклусив гэрээтэй эм бол сонгогдсон байна гэсэн үг. Эмийн үйлдвэрийн хувьд болохоор яг бид нарын судалгаанд байгаа эм дотроос 34 нэрийн эм бол дотоодын үндэсний үйлдвэрийн эм байсан.

Тэгэхээр үндэсний үйлдвэрийн 29 хувьд нь буюу 40 хүртэл хувиар 25 хувьд нь буюу 2-оос 3 дахин нэмж борлуулсан дүн харагдаж байгаа. Эмийн сангийн хувьд болохоор нийт нөгөө хамрагдсан эмийн маань 200 эм бол эмийн сан дээр зарагдаж байсан гэсэн үг. Тэгэхээр эмийн сангуудад жижиглэнгийн үнэ 94 хувьд нь бол 45 хүртэл хувиар нэмж борлуулж байна гэсэн үг. Энэ бол яах вэ орон нутаг нийслэл гэдгээрээ бас нэг их айхтар ялгаа байхгүй байгаа. Тэгээд жишээ болгоод ингээд нэг

эм дээр бол авч үзэж байгаа. Жишээлэх юм бол олон улсын нэршилээрээ альбумин гээд эм байхад энэ эм маань худалдааны нэршилээрээ жишээлэх юм бол бүр юу манай судалгаанд орсон 6 нэрийн эм байхад харилцаа юу бөөний үнэ нь ч харилцан адилгүй байна.

Орон нутаг нийслэл нь ч гэсэн харилцан адилгүй. Тухайлах юм бол үнэтэй зарагдаж байна гэж харагдахаар байгаа. Тэгэхээр дундаж зөрөө бол бөөний үнэ бол орон нутаг нийслэл юу 6 хувь жижиглэнгийн үнэ бол 3 хувийн зөрөөтэй байна гэсэн юу дүн харагдаж байгаа. Тэгээд ер нь бол эмийн үнийн өсөлт ер нь юунаас болж байна вэ гэдэг байдлаар бид нар судалгааны явцад иргэдээс болоод ханган нийлүүлэх байгууллага, эмнэлгүүд дээрээ судалгаа авсан байгаа. Тэгэхээр ерөнхийдөө бол судалгаанд хамрагдсан иргэдийн 79.6 хувь нь зах зээл дээр борлогдож байгаа эм нь үнэтэй байна гэж үзсэн. Тэгээд энэ иргэд нь болохоор ер нь энэ эмийн үнэ нь юунаас ингээд болоод өндөр байна вэ гээд асуухаар иргэд бол даатгалаар хөнгөлөгдөж байгаа эмийн хувь хэмжээг бууруулах хэрэгтэй байна энэнээс болж үнэ нь нэмэгдээд байна гэж дийлэнх нь хариулсан байгаа бол зах зээл дээр нийтлэхээр барааны үнэ нэмэгдэж байна гэдгийг бас нийтлэг хариулсан байгаа.

Эмийн сангийн ажилчдын хувьд бол нийлүүлэгчийн үнэ өссөнтэй, мөн тээвэрлэлтийн зардал нэмсэнтэй холбоотойгоор эмийн үнэ өсөж байна гэж санал асуулгад хариулсан бол эм ханган нийлүүлэх төв буюу бөөний төвийнхөн бол мөн адилхан хариулахдаа тээвэрлэлтийн зардлыг хэлсэн. Валютын ханиш үйлдвэрлэгчийн үнийн өсөлт нь энэ үнийн өсөлт нь нөлөөлж байна гэж үзсэн. Эмийн үйлдвэрүүдийн ажилчдын хувьд бол сав баглаа, боодол, туслах бодисын үнийн өсөлт, үйлдвэрийн эмийн үнэд нөлөөлж байна. Мөн валютын ханиш тээвэрлэлтийн

зардал эмийн үнийн өсөлтөд нөлөөлж байна гэж энэ асуумжаар хариулсан байж байгаа. Тэгээд ер нь бол судалгаанд хамрагдсан иргэдийн 63.4 хувь нь сарын хугацаанд эм эмийн худалдан авалтад 100 мянга хүртэлх төгрөгийг зарцуулж байна гэж хариулсан байгаа. Тэгээд эмийн үнэтэй холбоотой ер нь цаашид сайжруулах ямар шаардлагатай зүйлсүүд байна вэ гэдэг дээр бол иргэдийн хувьд бол эмийн үнийг тогтвортой байлгаж, жишиг үнийг тогтоох эмийн сангуудаар зарж байгаа эмийн үнийг ижил болгох ханган нийлүүлэх байгууллагуудын үнийн хөөргөдлийг бууруулах, үнийн өсөлтийг зохицуулах, даатгалаар олгож байгаа эмийн нэр төрлийг нэмэгдүүлэх, хүүхэд, өндөр настанд чиглэн хэрэглэдэг эмийн үнийг бууруулах гэдэг асуудлуудыг тавьсан бол эм хангамжийн байгууллагуудын төлөөлөл бол тээвэр, валютын ханишийн тогтвортой байдлыг хангах, зардлын хүүг бууруулах, ААН-үүдийг бодлогоор дэмжих зайлиггүй шаардлагатай эмийн нэр төрөл дээр татварын бодлого гаргаж хөнгөлөлт үзүүлэх, чөлөөт зах зээлийн эдийн засгийн зарчим баримтлах, гааль, НӨАТ-аас чөлөөлөх, хөнгөлөлт үзүүлэх гэдэг ийм саналуудыг өгсөн байж байгаа.

Тэгээд манай хяналт үнэлгээний явцад бол ЭМЯ-ны бас хяналт үнэлгээнээс мэргэжилтэн оролцоод даатгалаас олгож байгаа эм дээр бас үнэлгээ хийсэн. Дээр нь манай энэ нөгөө саяын дурдсан 50 нэрийн олон улсын 200 нэрийн худалдааны нэрээр ингээд эмээсээ ингээд харьцуулаад үзэхээр нэг ёсондоо бид нарын судалгаанд байгаа даатгалаар өгдөг эмүүдийн 20 хувь нь даатгалын босго үнэ нь бөөний үнээсээ бага байгаа дүн харагдсан.

Тэгэхээр энэ нь юу гэж байна вэ гэхээр нэг талаараа энэ иргэдэд худалдан авах боломжийг нь хязгаарлагдахаас гадна хангамжийг бас хязгаарлах үндэслэл болж байна гэж хэлэхээр байгаа юм. Яагаад вэ гэхлээр бөөний үнэ нь даатгалаар лимит

тавьсан хамгийн нөгөө босго үнэ гээд энэнээс дээшээ гаргаж болохгүй гэдэг үнэ байгаа шүү дээ. Тэр үнэ нь бөөний үнээсээ бага болчихоор нөгөө эмийн сангууд жишээлбэл зарим өндөр үнэтэй эмэнд 50 мянга, 10 мянга, 20 мянган төгрөгийн алдагдалд дорж зарах гээд байгаа учраас бараг эмийн санд нь байгаа хэрнээсээ хүн авъя гээд ороод ирэхээр наад эм чинь манайд байхгүй гээд сууж байх жишээтэй. Яагаад вэ гэхлээр өөрөө алдагдалд орох гээд байгаа учраас гэж тайлбарлаж байгаа. Энэ нэг ийм дүн харагдаж байгаа.

Мөн даатгалаас бол манай ажлын хэсэгт ажилласан гишүүдээс гаргасан мэдээллээр бол 2021 онд даатгалаас 69 тэрбум, 2022 онд 81 тэрбум төгрөг санхүүжилт олгосон байна. Нийслэлд бол 798 эмийн санд 31 тэрбум, 2022 онд 759 эмийн санд 47 тэрбум төгрөг олгосон байгаа. Тэгээд нийтдээ 18 бүлгээс 15 нь бол өмнөх оны үзүүлэлтээс 3 бүлэг нь бууралттай байгаа. Тэгээд хамгийн ер нь өндөр дүнтэй санхүүжилт нь зүрх судасны тогтолцоонд нөлөөлөх эмүүд байж байгаа.

Тэгээд ер нь бол 65-аас дээш насны иргэд даатгуулагч хамгийн их даатгалын хөнгөлөлттэй жороор үйлчлүүлсэн дүн харагдаж байна гэж гарсан байгаа. Тэгээд эмийнх нь нэр төрлийн хувьд бол хамгийн өндөр санхүүжилт авсан 4 эм гэж бас санхүүжилтээрээ энэ 4 юм гарч ирсэн байж байгаа.

Тэгээд бид хэдийн хяналт үнэлгээний бас нэг асуудал бол эмийн чанарын асуудал байсан.

Тэгээд яах вэ Эмийн агентлаг дээр улсын байцаагч нар мэргэжлийн хяналтаас шилжиж ирсэнтэй холбоотойгоор хяналтын чиг үүрэг эмийн агентлагт шилжиж ирсэн. Гэвч эрх зүйн зохицуулалт бүрдээгүйгээс хяналт шалгалтын байцаагч

нар маань хяналт шалгалт хийх, зөрчил шалган шийдвэрлэх ч эрх үүсээгүй байсан цаг үед энэ удирдамж гарсан учраас ихэвчлэн асуумж судалгаа буюу шалгуураар үнэлэх байдлаар хяналт үнэлгээгээ хийсэн байж байгаа. Тэгээд энэ хүрээндээ бол эд нар эмийн чанарын байдлаар нээлттэйгээр иргэдээс асуумж авсан эм эмийн мэргэжилтнүүдээсээ бас асуумж судалгаа авсан. Тэгэхэд бол нийт судалгаанд хамрагдсан эмийн мэргэжилтнүүдийн бол 49 хувь нь эмийн чанар сайн гэж үзсэн бол нийт судалгаанд хамрагдсан иргэдийн 64 хувь нь бол эм чанаргүй байна гэж авсан байгаа. Энэ бол иргэдийн хувьд 668 иргэн, аж ахуйн нэгжүүдийн хувьд 356 мэргэжилтнүүд хамрагдсан байж байгаа.

Ер нь бол эмийн чанар үйлчлэхгүй байгаа шалтгааныг та хэд юу гэж үздэг вэ гэдэг дээр бол хадгалалт, тээвэрлэлтийн дэглэм, хууль тогтоомжийн хэрэгжилт бүртгэлгүй эмийн асуудлыг бол хөндөж тавьсан байж байгаа. Тэгээд ер нь бол энэ эмийн чанартай холбоотой иргэдийн санал юу байсан бэ гэхээр жороор олгох эмийг эмчийн зааврын дагуу зохистой хэрэглэх лабораторийг сайжруулах хяналтыг сайжруулах, зар сурталчилгааны хяналтыг сайжруулах, иргэдийн эрүү эрүүл мэндийн боловсролыг сайжруулах, бүртгэл мэдээллийг сайжруулах, эмч эм зүйчийн мэргэжил мэдлэгийг дээшлүүлэх гэж санал хэлсэн бол эм зүйч эм найруулагч нар эмч нарын хувьд бол эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, зохистой хэрэглээг төлөвшүүлэх, тоног төхөөрөмж лабораторийн тоног төхөөрөмжийг сайжруулах хяналтыг сайжруулах гэсэн ийм саналууд хэлсэн байгаа.

Стандартын хэрэгжилтийн хувьд бол эм ханган нийлүүлэх, эмийн сан, үйлдвэр, эмнэлгүүд дээр шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ хийж үзсэн байгаа. Энэ үнэлгээний явцад бол хяналт үнэлгээнд хамрагдсан эмийн сангийн 26.1

хувь нь бол зориулалтын дагуу эм эмнэлгийн хэрэгслийг хадгалахгүй байна. Эм ханган нийлүүлэх байгууллагын бол 67.8 хувь нь нөгөө татан авсан эм, эмнэлгийн хэрэгслийнхээ чанар тээвэрлэлтийн нөхцөлийг шалгахгүй байна. Эм ханган нийлүүлэх байгууллагын 39.4 хувь нь эмийг түгээхдээ хянаж баримтжуулалт нь хангалтгүй байна, 37.5 хувь нь бол чанарын аюулгүй байдлын тайланг гаргаж мэдээлэхгүй байна. Нийтдээ эмнэлгийн эмийн сан сангийн хувьд энэ нэлээн өндөртэй гарсан 56.2 хувь нь стандартад заасан хүний нөөцөөр хангах хангалтгүй байна. Шалгалтад хамрагдсан эмийн сангийн 46.8 хувь нь бол жоргүй болгох буюу хүчингүй жороор буюу алдаатай жороор эмээр үйлчилж байна гэж авсан. Яах вэ энэ хяналт үнэлгээнийхээ хүрээнд бол тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байсан үйл ажиллагааг таслан зогсоох арга хэмжээ авсан, хугацаа дууссан эмийг бол устгуулах арга хэмжээ авсан байж байгаа.

Тэгээд хяналт үнэлгээний дүнг дүгнэлтийг юу гэж хийсэн бэ гэхээр эмийн үнэ хэлцлийн үнээс эцсийн хэрэглэгчид хүрэхдээ дунджаар 1.1 дахин нэмэгдсэн байна аа. Энэ үнэ нэмэгдэхэд нөлөөлсөн гол хүчин зүйлүүд нь инфляцын өсөлт төгрөгийн валюттай харьцах ханшийн сулрал, ковид цар тахлын үеийн эмийн үнийн өсөлт тэр чигээрээ үргэлжлээд буухгүй байгаа. Тэвэрийн зардлын өсөлттэй холбоотой байна гэж манай хяналт үнэлгээний багаас дүгнэсэн байж байгаа.

Ер нь бол цаашидаа бид хэд юу хэрэгжүүлэх шаардлагатай байна вэ гэхээр эмийн энэ чанар үнэтэй холбоотойгоор эрх зүйн орчныг боловсронгуй болгох зайлигүй шаардлага байна. Тухайлах юм бол эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, хангамж, зохицуулалт, үнэтэй холбоотой нэгдсэн цахим зохицолтой бүрдүүлэх хэрэгтэй байна.

Эмийн үнийн ил тод байдлыг хангах чиглэлээр эмийн үнийн эмийн сангуудын эм, эмнэлгийн хэрэгсэл, ханган нийлүүлэгч байгууллагуудын үүрэг хариуцлагыг нарийвчлан тусгаж оруулах. Мөн нийтийн эрх ашгийг хамгаалах зорилгоор тасалдал үүсэж байгаа эм, эмнэлгийн хэрэгслийг бол ханган нийлүүлэх байгууллага нийлүүлдэг байх шаардлага зохицуулалтыг тусгаж өгөх. Энэ зөвшөөрлийн болоод Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн зөрчилдсөн асуудлуудыг шийдвэрлэх. Тэгээд үндэсний эмийн үйлдвэрүүдэд хөнгөлөлт, зээл олгох, гаалийн татвараас чөлөөлөгдөх энэ асуудлыг бол эрх зүйн орчноор зохицуулах чиглэлээр сайжруулах шаардлага байна гэж үзсэн байгаа.

Мөн Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар байгуулагдсан Монгол Улсад зохицуулалтын чиг үүрэг шинээр бий болж ирсэнтэй холбоотойгоор олон улсын жишигт нийцсэн эмийн лабораторийг бий болгох лабораторийн тоног төхөөрөмжийг сайжруулах хүний нөөцийг чадавхжуулах шаардлагатай байна.

Хилийн ер нь бол зах зээл дээр улсын бүртгэлд бүртгэгдээгүй бүртгэлийн загвараас зөрөөтэй эм байгаад байгаа нь импортоор орж ирж байгаа эмүүдийн дийлэнх хувь эзэлдэг учраас хил дээр дээр байгаа хяналтыг сайжруулах хилийн нэвтрэх цэг тэр тусмаа ачаа карго илгээмжээр ирж байгаа ачааны хяналтыг чангатгах шаардлагатай байна гэж үзэж байгаа. Тэгээд ер нь бол нэгдсэн тийм цахим тогтолцоо бүрдэх юм бол энэ бас хяналт зохицуулалт тодорхой болоод явах юм гэж харж байгаа.

Тэгээд ерөнхийдөө бол хяналт үнэлгээ хийснээс хойш манай агентлагийн хувьд гол гол ажил нь юу байсан бэ гэхээр Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль шинэчилсэн найруулгаар батлагдах гээд

ажлын хэсэг гараад ажиллаж байгаа. Тэгэхээр энэ хууль дээрээ эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалт, үнэ, худалдан авалтыг маш нарийвчлалж өмнө нь байдаггүй шинэ шинэ зохицуулалтуудыг нэмэлтээр тусгаж төсөлд тусгуулсан байж байгаа. Мөн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалтын талаар шинэ санал өгч шинэ зохицуулалт тусгуулсан. Энэ хүрээндээ нэг эх үүсвэрээс эм худалдан авах эм эмнэлгийн хэрэгслийн журмыг Засгийн газар батлахаар тусгасны дагуу манай яаман дээр ажлын хэсэг гараад энэ журмаа боловсруулж байна.

Мөн эмийн тендерийн шалгаруулалт дээр эмийн үнэ хамгийн өндөр шалгуур эзэлдэг байсан бол энэ эм дээр бол чанар нь 70 хувь байх ёстой юм. Үнэ нь 30 хувь байна гэдэг асуудлыг манайхаас яамнаас тавьсны үндсэн дээр энэ шалгуурт өөрчлөлт оруулах гээд саналыг манайх боловсруулаад Сангийн яам руу хүргүүлчхээд байж байгаа.

Хяналт үнэлгээ, тандалт судалгаа, үнэлгээ, шалгалт үнэлгээг эрчимжүүлэх чиглэлээр бол байцаагч нар маань сая 5 сарын 15-наас эрхтэй болсноосоо хойш одоогийн байдлаар төлөвлөгөөт бус шалгалтын хүрээнд 54 зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаа явуулаад прокурорын хяналт доороо үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнээс гадна тандалт судалгааг бас манай байгууллага дээр чиглэл чиглэлээрээ хийж байна. Тухайлах юм бол зар сурталчилгааны асуудал байгаа. Манай бас энэ хяналт үнэлгээнд бас орсон асуудал. Зөвшөөрлийн тухай хуулиар бол эмийн телевизээр явуулах энгийн зар сурталчилгааны зөвшөөрлийг эмийн агентлаг олгохоор байгаа.

Тэгээд манайх үнэлгээ хийгээд зөвшөөрөлгүй зар сурталчилгаа явуулж байгаа ААН-үүд дээрээ Зөвшөөрлийн хуулийн дагуу зарим байгууллага дээр арга хэмжээ аваад мөн Зөвшөөрлийн тухай хуультай уялдуулаад телевизээр явах зар сурталчилгааны журам буюу харилцаа холбооны даргын баталсан тогтоол дээр эмийн зар сурталчилгаатай холбоотой гол гол заалтуудыг оруулснаас сүүлийн үед бол яг энэ тогтоол маань хэрэгжиж байж явж байна аа. Мөн импорт бид нарын хяналт үнэлгээний явцад бол бас нэг ийм асуудал байсан. Нийтдээ манай дээр 2022 оны байдлаар гэхэд 491 эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох зөвшөөрөлтэй байгууллагын 115 орчим нь бол импорт хийгээгүй байна гэсэн дүн байгаа.

Тэгэхээр энэ дээрээ бид нар дэлгэрүүлээд судалгаа хийгээд цаашидаа бол энэ тусгай зөвшөөрөл авчхаад импорт хийхгүй байгаа ААН-үүд дээрээ үргэлжлүүлэн тандалт судалгаа хийгээд хуульдаа болоод стандартдаа зохих өөрчлөлтүүдийг ороод ер нь бол зөвшөөрлийг тодорхой хэмжээгээр хязгаарлах тоог цөөрүүлэх чиглэлээр хүний нөөц тусгай зөвшөөрөлтэй байгууллагын хяналт үнэлгээг сайжруулах чиглэл дээр нэлээд эрчимтэй ажиллаж байна аа.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Ж.Чинбүрэн: ШӨХТГ-ын Хэрэглэгчийн эрхийг хамгаалах зар сурталчилгааны газрын дарга Тэрбиш. Нэмж танилцуулах зүйл бий юу?

Ц.Тэрбиш: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе ээ.

Би тэгээд Энхтуяа даргын яриатай давхиулахгүйгээр яг одоо өөрийнхөө байгууллагын хамааралтай зарим нэг нэмэлт мэдээлэл хийе ээ. Ер нь эмийн зах зээлийн судалгааг бол бүтцийнх нь хувьд 2

хувааж ангилж авч үзсэн. Хэвтээ болон босоо гэж ангилж үзсэн.

Хэвтээ гэдэг нь бол олон улсдаа ерөнхийдөө ямар ойлголтыг хэлж байна вэ гэхээр нэг ижил бүтээгдэхүүнээр зах зээлд борлуулалт хийж байгаа ААН-үүдийг хэлж байгаа. Тухайлах юм бол үйлдвэр нь үйлдвэртэйгээ, эм ханган нь эм хангантайгаа өрсөлдөх ийм орчин нөхцөлийг хэлж байгаа.

Босоо хамаарал гэдэг нь болохоор түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтээс эцсийн хэрэглэгчид жижиглэнгээр худалдаалах үйл явц хүртэлх энэ шат дамжлагад байгаа ААН-үүдийг бол энэ босоо хамааралтай ААН-үүд гэж авч үздэг.

Энэ хүрээнд бол импорт, үйлдвэр гэдэг нь бол анх эмийг зах зээлд нийлүүлж байгаа эх сурвалж болж байгаа. Ингээд эм ханган нийлүүлэх байгууллагаар дамжаад эмийн сангийн үнээр борлуулагдах ёстой ийм эрх зүйн орчин үйлчилж байна гэж харагдаж байгаа биз. Үнийн судалгааны хувьд дэлгэрэнгүй ярьсан учраас давхиулж яриад яах вэ. Ерөнхийдөө бол 80 хувьд нь эм ханган нийлүүлэх байгууллага бол эмийн сан дээр үнийн өсөлт бол 30-аас 40 хувь. Энэ тэгэхдээ яах вэ үнийн өсөлт биш нөгөө хил үнэ буюу анхдагч үнээс нэмж зарж байгаа үнэ. Үүнээсээ 20-оос 26 хувьд нь бол эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн үйлдвэр, эмийн санд илүү өндөр өсөлт бол ажиглагдаж байна. Энэ шалтгаан нөхцөл нь бас юу байна вэ гэдэг дээр бид нар бас анхаарал тавьж үзсэн.

Ингэхэд Эксклусив гэрээ буюу одоо дистрибьютерийн эрх тухайн нутаг дэвсгэрт зөвхөн нэг ААН-д тухайн лицензтэй эмээ борлуулах ийм эрх өгч байгаа тохиолдлыг хэлж байгаа. Энэ тохиолдолд бас зах зээлийн ийм давуу байдал бий болж байгаа учраас энэ давуу

байдлаа ашиглаж бас энэ үнэд бас үнэ бүрдэлтэд сөргөөр нөлөөлж байгаа ийм хүчин зүйл байна уу гэдэг дээр анхаарал хандуулсан.

Ингээд судлахад Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд бол эм ханган нийлүүлэх байгууллага гэж юуг хэлж байна вэ гэхээр эмийн сан, эрүүл мэндийн байгууллагад бөөний үнээр нийлүүлэлт хийж байгаа этгээдийг хэлнэ гэж. Тэгвэл эмийн сан гэж ямар этгээдийг хэлэх вэ гэхээр нийт хүн амыг эмээр хангах, жижиглэнгийн үнээр нийлүүлэлт хийж байгаа этгээдийг хэлнэ гээд хуульд тодорхой заасан. Гэтэл мөн хуулийн 11.1.5-д, эм эмнэлгийн хэрэгслийн ханган нийлүүлэх байгууллага нь иргэдэд ханган нийлүүлэх байгууллага нь шууд хэрэглэгчтэй харилцаж нийлүүлэлт хийхийг хориглоно гээд ингээд заачихсан.

Гэтэл яг бодит байдал дээр эм ханган нийлүүлэх болон эмийн санд хамаарал бүхий нэг этгээдэд тусгай зөвшөөрөл давхардуулан олгосноос энэ босоо хамаарал бий болсон байна гэдэг ийм дүгнэлтийг бас хийж болохоор нөхцөл байдал харагдсан. Мөн тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжүүд нь яг тусгай зөвшөөрлийн болзол шаардлагад нийцэх үйл ажиллагаагаа хийж чадаж байна уу үгүй юу. Тухайлах юм бол ханган нийлүүлэх байгууллагууд нь бас дотороо хамаарал бүхий хэд хэдэн ААН болж ингээж шатлал үүсгэж бас задарч байсан. Тэгээд энэ нь бол шат дамжлага бүрд бас өртөг зардал шингээж эмийн үнэ бас өсөхөд бас тодорхой хэмжээгээр нөлөөлж байна гэдэг бас нэг ийм дүгнэлтийг хийж болохоор харагдаж байсан. Ер нь бол зах зээлийн нөхцөл байдлыг бас бид нар авч үзсэн. Нэг гол 2 зүйл ажиглагдаж байгаа.

Нийтдээ одоо 2021, 2022 онд 250 гаруй эм ханган нийлүүлэх байгууллага импорт тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж байсан. Үүнээс 2021 онд

117, 2022 онд бас 100 гаруй аж ахуйн нэгж эм ханган нийлүүлэх эмийн импорт хийж байсан. Бусад нь бол дотоодоос дамжуулан эм ханган нийлүүлэлт хийж байгаа ийм нөхцөл байдал харагдаж байсан. Тэгэхээр түрүүний ярьсан тэр шат дамжлага үүсэх бас нэг ийм нөхцөл үүнээс үүдэлтэй юм уу гэж бас ингээж ажиглагдаж байсан.

Тухайлах юм бол гол нийлүүлэлт хийдэг Монос фарм трейд, Ази фарм, Эм Импекс концерн гээд энэ компаниудаас эм ханган нийлүүлэх байгууллагууд бартер солилцоо гэдэг юм уу, урамшуулалт үнэ гэдэг байдлаар бас ингээд эм аваад цааш нь дамжуулж худалдаж байгаад ийм тохиолдлууд бас харагдаж байсан.

Ингээд Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 219 дүгээр тогтоолоор энэ зүй ёсны монопол болон давамгай байдалтай аж ахуй эрхлэгчид тогтоох журам байдаг. Энэ журмын дагуу бид нар зах зээл дээр монопол болон давамгай байдалтай аж ахуй эрхлэгч байна уу, үгүй юу гэдэг ийм судалгааг бас тогтмол хийж байдаг. Өнгөрсөн хугацаанд бол тарилгын шингэний зах зээл дээр Айвико компани давамгай байдалтай, эм жижигжлэнгээр борлуулах зах зээлд Монос Улаанбаатар компани давамгай байдалтай гэсэн ийм нөхцөл байдал тогтоогдсон.

Ингээд үргэлжлүүлээд бид нар эм ханган нийлүүлэх зах зээл дээр энэ зүй ёсны монопол болон давамгай байдалтай аж ахуй эрхлэгчийг тогтоох судалгааг явуулж хийх шаардлагатай юм байна гэж үзээд ингээд энэ хяналт шалгалтын нэгдсэн дүгнэлт гарсны дараа үргэлжлүүлээд бас хэд хэдэн ажлыг зохион байгуулсан байгаа.

Ингээд судалгаа хийхэд Монос Фарм трейд компани нь бол зах зээл дээр бас давамгай байдалтай эм ханган нийлүүлэх зах зээл дээрээ давамгай байдалтай аж ахуй эрхлэгч юм байна гээд

ШӨХТГ-ын хуралдаан гээд ингээд бүтцэд ажилладаг. Энэ хуралдаанаар оруулж шийдвэр нь гарсан байгаа.

Монос Фарм трейд ХХК-ийг эм ханган нийлүүлэх зах зээлд давамгай байдалтай аж ахуйн нэгж гэсэн ийм агуулгаар давамгай байдалтай гэж тогтоогдсон байгаа.

Ингээд мөн шалгалтын хүрээнд бас нэг ажиглагдсан зөрчилтэй зүйл юу байсан гэхээр эмийн Новардис эмийн хүртээмжийг сайжруулах төсөл гэж хэрэгжиж байсан. Энэ төслийг хэрэгжүүлэх явцад 3 ААН-тэй ЭМД-ын ерөнхий газраас гэрээ хийсэн байсан. Хамтарч ажиллах гэрээ хийсэн. Тухайлах юм бол Монос фарм трейд, Ази фарм, Эм импекс концерн гээд 3 компанитай гэрээ хийсэн байсан.

Ингээд гэрээ хийх явцдаа болохоор зөвхөн эдгээр 3 компанийн Эм эмийн сангаар борлуулалт хийнэ гэсэн ийм өрсөлдөөнийг хязгаарласан заалт гэрээнд тусгагдсан байсан. Ийм учраас энэ өрсөлдөөнийг хязгаарласан Өрсөлдөөн өрсөлдөөний тухай хуулийг зөрчсөн энэ заалтаа бол хүчингүй болгож гэрээндээ өөрчлөлт оруул гэдэг ийм шаардлагыг тавиад ингээд ЭМД-ын ерөнхий газраас ингээд энэ зөрчлөө арилгалаа гэсэн ийм хариугаа өгсөн байгаа. Мөн Эм эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газарт бид нар ер нь энэ тусгай зөвшөөрлийн олголт цуцлах энэ нөхцөл шаардлагадаа бас ингээд шаардлагаа бас өндөрсгөж ажиллах ийм хэрэгцээ шаардлага байна гэдэг ийм зөвлөмжийг мөн агентлагийн дарга улсын ерөнхий байцаагчийн шаардлага зөвлөмжийг хүргүүлсэн байгаа. Мөн нөгөө Монос Фарм Трейд компанийг давамгай байдалтай аж ахуй эрхлэгчээр тогтоосонтой холбоотой агентлагийн даргын хяналт шалгалтын удирдамж батлагдаж ажилласан.

Энэ давамгай байдлаа ер нь зах зээл дээр буруугаар ашиглаж байгаа нөхцөл байдал байна уу, үгүй юу гэдгийг илүү нарийвчилсан байдлаар шалгах ийм удирдамж батлагдсан. Ингээд удирдамжийн дагуу шалгаад үзэхэд Монос Фарм Трейд компани нь Өрсөлдөөний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, 7.1.6-д заасан буюу ялгавартай үнэ зах зээл дээр санал болгох дахин борлуулах үнийг тогтоох ийм зөрчил тогтоогдож байна гэж үзээд Монос Фарм Трейд компани дээр Зөрчлийн тухай хуульд заасан үндэслэлийн дагуу нийтдээ 8.4 тэрбум төгрөгийн торгууль ноогдуулсан.

Ийм ажлуудыг бол хийгээд явж байна аа. Ингээд товчхондоо мэдээлэл нэхдэг юм байна.

Ж.Чинбүрэн: Шадар сайдын албан дээр хийгдсэн шалгалтын үр дүнг танилцуулж дууслаа.

Асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү?

Жаргалмаа гишүүн, Батлут гишүүн, Сандагаа гишүүн дарсан уу?

Сандаг-Очир гишүүнийг оруулаарай ингээд орчихлоо би бас өөрөө асууна аа.

Жаргалмаа гишүүний микрофоныг нээе асуулт асууя.

Б.Жаргалмаа: Манай Түр хороо байгуулагдахдаа анх эмийн үнээс гадна эмийн чанарын асуудалд бид нар хяналт тавих ёстой гэдэг ийм бас зорилгыг агуулсан байгаа. Тэр ч үүднээсээ Түр хороо байгуулагдаад өнөөдөр ажиллаж байгаа. Ямар ч гэсэн манай шинжээчид тодорхой хэмжээнд бас ажлаа тайлагнаж байгаад баярлалаа. Тэгэхдээ бид зөвхөн тайлан сонсохоосоо гадна бас тодорхой хэмжээний үр дүнг бид нараас олон нийт бол нэхнэ. Энэ дээр зөвхөн нэг үнийн

өсөлтөөс гадна бид нар эмийн чанарын асуудлыг бас ярина гэдэг ийм зүйл ярьж байсан. Тэгээд энэ хаяг шошгын зөрчилтэй Монгол Улсын эмийн бүртгэлийн загвараас зөрөөтэй ийм эмнэлгийн хэрэгсэл илрүүлсэн гэдэг ийм мэдээлэл байна л даа.

Тэгэхээр бид нар ер нь юу хэрэглээд байгаа юм бэ гэдэг дээр олон нийт эргэлзэх хэмжээний нэг төрлийн эмийг бид нар хэрэглэдэг байлаа гэхэд гаднын улсын яг тэр ижил төрлийн яг тэр эмийг нь аваад хэрэглэхээр үйлчилгээ нь өөр байдаг. Бид нар уг нь энэ ч байдлыг л уг нь арилгая. Монгол Улсад чанартай эм орж ирж байна уу, үгүй юу, тэрийг бас тандан судалъя гэдэг зорилгоор энэ ажлын хэсэг байгуулагдаж байсан. Ер нь бид нар яг ийм эмийн чанарыг харьцуулсан судалгаа Монгол Улсад орж ирж байгаа бүртгэлтэй эмийн чанар найрлагад хяналт тавьж чадсан уу? Энэ тал дээр ер нь хэр ажиллав гэдэг нэг зүйлийг тодруулмаар байна.

Тэгээд ер нь нэг хэдхэн компани дистрибьютер буюу оруулж ирдэг. Тэгээд энэ дээр бас нэг өөр нэр томьёоллоор байсан эксклюзив билүү тэ? Энэ оруулж ирж байгаа компаниудынхаа Монголд орж ирж байгаа эмийн дээжийг гэдэг юм уу ер нь хэдий хугацаанд бид нар чанарыг нь шалгадаг юм оо? Эмийн найрлагад бид нар чалгадаг юм оо. Зүгээр олон улсын лабораториор хүлээн зөвшөөрөгдсөн гэдгээрээ шууд хүлээж авдаг юм уу эсвэл үнэхээр орж ирж байгаа найрлага нь тийм ээ тэр хэмжээндээ байгаа гэдэг зүгээр итгэлээр ингээд гэрээний үндсэн дээр бид нар хүлээгээд авчихдаг юм уу? Монгол Улс өөрөө тэрийг хянан шалгах лаборатори нь бидэнд байна уу? Ер нь энэ шинжилгээгээ ер нь хэрхэн яаж хийдэг юм бэ гэдэг нэг ийм зүйлийг тодруулах гэсэн юм. Монгол Улсад өөрсдөө үйлдвэрлэж байгаа эм эмийн бүтээгдэхүүнийхээ чанарыг бас тодорхой хэмжээнд дотоодын лабораториудаа хянаад оруулдаг байх.

Тэгэхлээр энэ дээр ер нь ямар ажил хийгдсэн бэ гэдэг ЭМД-ын сангаас олгогдож байгаа хөнгөлөлттэй эмийн босго үнийг шинэчлэх шаардлагатай байна гэсэн нэг ийм дүгнэлт гараад байна л даа.

Энэ дээр тодруулъя. Өөрөөр хэлэх юм бол бид нар ЭМД-аар би нөгөө өөрийнхөө уудаг эм дээр л ярих гээд байна л даа. Тэр карбо мезапин гээд эм ууж байхад дахиад бид нар өөр төрлийн карбо мезапиныг авах гэхээр тэр нь чанарынх нь нөгөөдөх харьцуулсан дүн мэдээ гэдэг юм уу эмийн юун дээрээ танилцуулга дээрээ байдаггүй. Хаяг шошгын зөрчилтэй гээд байгаа нь энийг хэлэх үү эсвэл бид нар яг Үйлчлүүлэгчдэд шаардлагатай тэр эмийн тайлбар мэдээллийг шошго дээрээ тавьж чадаж байна уу, үгүй юу гэдэг дээр хяналт тавих тэр боломж нь ер нь байдаг уу? Даатгалд хамруулсан дээд үнийг тогтоож эмийн босго үнэ нь тухайн эмийн бөөний үнэтэй ойролцоо байгаа нь эмийн сангууд тулгамдсан асуудал болохоос гадна эмийн хүртээмжийг бууруулах магадлалтай байна гэсэн ийм нэг дүн гарсан байна шүү дээ тэ.

Энийг нэг тайлбарлаж өгөөч ээ. Өөрөөр хэлэх юм бол ЭМД-аар бид нар энэ хэмжээнд үнэ тогтоогдоно. Даатгал нь тэрийг нь даана гэдгийг бид нар тогтоож өгчхөөд байгаа шүү дээ. Гэтэл тэр эмийг дахиад шинэчлэхээр энэ эм чинь дахиад өсөх юм биш үү? Уг нь саяын дүн шинжилгээн дээр 100 төгрөгөөр орж ирж байгаа эм 209 төгрөг болоод явчхаж байна шүү дээ тийм ээ. Бүхэл бүтэн 100 дахин нэмэгдчихээд байгаа юм. Уг нь болж өгвөл бид нар эмийг яаж тийм ээ хэрэглээнээс хэрэглээг нь багасгах талаар нь өөр боловчиг бид нар хэрэглэж байгаа эмийнхээ чанар үнийн асуудлыг л бид нар ярьж байгаа шүү дээ. Тэгэхээр яавал бид нар одоо дахиад дараагийн гаргалгаа байгаа юм бэ гэдэг нэг ийм хэд хэдэн асуулт байна. Энэ дээр тайлбар аваадахъя тэгэх үү?

Ж.Чинбүрэн: Хоёрдугаар микрофон дээр суучих Энхтуяа дарга 2 дугаар микрофон дээр хариулчих голынход.

Нэлээн тодорхой асуултууд асуусан шүү. Хариулт илгээсэн хүнд Бейсен гишүүнийг оруулчхаарай нэрсэнд Бейсен гишүүнийг оруулчхаарай. Тэгээд Бейсен гишүүн бас хууль яах гэж байгаа юм байна? Би Батлут Сандаг-Очир гишүүн 2-оос хүсэлт хүсэж байна. Урдуураа оруулаад асуулт асуулгачих боломж байна уу? Тэрийг ярилцъя. Хариултаа сонсьё.

Д.Энхтуяа: Баярлалаа. Жаргалмаа гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр хяналт үнэлгээний явцад зөвхөн үнэ гэхгүй бас чанарын асуудлыг оруулъя гэдэг асуудал яригдаад удирдамжид орсон байгаа. Бас энэ хүрээндээ хийсэн байгаа. Тэр хаяг шошгын асуудал гэдэг ер нь бол эмийн хаяг шошго дээр тийм тийм тийм мэдээллийг агуулна гээд одоо хүчин төгөлдөр байгаа Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 18 дээр заачихсан байгаа.

Тэгэхээр нэг хаяг шошгын зөрчилтэй эм гэдэг нь юу вэ гэхээр тэр эмийн хуулийн 18-д заасан хаяг шошго юунд заасан мэдээлэл нь бүрэн агуулаагүй байгаа эмийг бас хэлж байгаа. Дээр нь энэнээс гадна юу вэ гэхээр Монгол Улсын эмийн бүртгэлд бүртгэгдээгүй бас орж ирнэ. Бүртгэгдсэн одоо жишээлэх юм бол Амоксициллин гээд бүртгэгдсэн Германы Денкийнх байлаа гэж бодоход яг тэрэнтэй адилхан өөр үйлдвэрийнх бүртгэгдээгүй гэж үзнэ. Тэгэхээр яг тэрүүгээр бүртгэгдээгүй бүртгэлийн загвараас зөрөөтэй, хаяг шошгын зөрчилтэй, хаяг шошгын зөрчилтэй гэдэг бол импортын эмээс гадна үндэсний үйлдвэрийн эм дээр хамаарна. Бас эмийн санд найруулсан дотоодын бэлдмэл буюу бид нарын

ярьдгаар дээр үеийн усан эм гэдэг дээр бас энэ яригддаг байгаа.

Тэгэхээр хаяг шошгын зөрчилтэй бүтээгдэхүүн гэдэг маань хяналт шалгалтын явцад бол бас илрээд хураагдаж устгуулсан байж байгаа. Тэгээд ер нь чанарын хувьд бид хэд яаж үзэж байна вэ гэхээр ер нь бид нар чанартай эм хэрэглэнэ гэдэг хамгийн анхны анхан шатны шаардлага шалгуур бол Монгол Улсын эмийн бүртгэлд бүртгэх асуудал байгаа. Бүртгэхдээ бол бид нар тодорхой дүрэм журмын дараа шалгууруудын дагуу бүртгээд явж байгаа.

Бүртгэгдэж байгаа бүх эм дээр бол шинжилгээ хийгдэж байгаа. Одоо эм бүгд дээр нь түүхий эд дээр ч адилхан эм дээр бүгд дээр нь шинжилгээнд хамруулаад шинжилгээнд хамруулсны дараа бүртгэлийн орон тооны бус шинжээч дүгнэлтээ гаргаад тэгээд эмийн зөвлөлийн хурлаар ороод бүртгүүлж байгаа. Тэгэхээр энэ бол бас хамгийн анхны чанарын гол шалгуур гэж үзэж байгаа. Явцын хувьд яаж байна вэ гэхээр эмийн импортын эмийн хувьд бол гааль дээр манай эмийн байцаагч нар гэж ГЕГ-ын харьяанд эмийн байцаагч нар ажиллаж байгаа. Энэ хэд гааль дээр гарсан журмынхаа дагуу импортын давтамжаас хамаараад 6-аас 3 сарын хугацаанд тухайн эмээс дээж авч хүргүүлнэ гээд гаалийн байцаагч нарын журам байгаа.

Тэгэхээр энэ хүрээндээ гаалийн байцаагч нар бас гаалийн, хилийн хяналтаа хийх явцдаа дээжээ өгч байгаа. Тэрнээс гадна манай агентлаг дээр байгаа эмийн байцаагч нар төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус хяналт шалгалтын явцад түүврийн аргаар дээж авч лабораторид шинжлүүлж өгч байгаа.

Мөн эмийн компаниуд бол өөрсдөө дотоод хяналтын буюу нөгөө эмийн гаж нөлөө аюулгүй байдлаа хангах гэдэг

зорилгоор давтамжаараа бас өөрсдөө дээж өгч явуулж байгаа. Түүнээс гадна бас иргэд байгууллага хууль хүчний байгууллагын хүсэлт гомдлын дагуу шинжилгээ хийж байгаа. Тэгээд манайх бол яг сүүлийн үед тандалт судалгаа бас нэлээн хийж байна.

Тухайлах юм бол зар сурталчилгаанаас гадна нөгөө юу билээ тайвшируулах үйлчилгээтэй. Нөгөө түрүүний хэлсэн манай хүүхдүүдэд нэлээн их хэрэглээд байгаа уналт таталтын эмийн тандалт судалгааг манай тандалтын газраас бас сая 6 сард хийсэн байж байгаа. Мөн энэ зар сурталчилгаагаар сурталчлаад байгаа эмүүдийн маань чанар ер нь ямар байгаа вэ гэдэг дээр бас тандалт судалгаа хийсэн байж байгаа. Мөн эмнэлэгт хэрэглэж байгаа зарим өргөн нэрийн нөгөө зүрх судасны шалтгаантай өвчлөлийн тэргүүлэх зэрэгт ороод байгаа зарим нэрийн эм дээр бас нэрийг нь онцлоод бас түүвэрлээд бас тандалт судалгаа хийгээд явж байгаа. Энэ хүрээндээ бол ер нь одоо үйлдвэрлэгч өөрөө чанартай эмийг үйлдвэрлэнэ. Чанар аюулгүй байдлыг үйлдвэрлэгч өөрөө хариуцна гэдэг утгаараа бид хэд энэ тандалт судалгаагаа дэлгэрэнгүй тухай бүр хийж, тайлангаа ирүүлэх, хяналт шинжилгээндээ тогтмол хамруулах гэдэг шаардлагыг бол ханган нийлүүлэх байгууллага болоод үйлдвэрүүддээ бол тогтмол тавиад тодорхой хэмжээгээр бас.

Ж.Чинбүрэн: 2 номерын микрофон дээр минут сунгая. Хариултаа гүйцээчихье.

Д.Энхтуяа: Үндэсний үйлдвэрийн үүд үйлдвэрийн хувьд бол түүхий эдийг шинэ юу эмийг үйлдвэрлээд хэрэглэхийн өмнө бүх түүхий эдийг заавал эм шинжлэгдэх лабораторид шинжлүүлж шинжилгээнд оруулдаг.

Тэгээд шинжилгээнээс гарсан тохиолдолд манай яг GP авсан бүх үйлдвэрүүд нь нөгөө итгэмжлэлээ авчихсан байгаа учраас итгэмжлэлийн хүрээндээ шинжилгээнд хамрагдана. Мөн хяналт шалгалт болоод өөрсдийн байгууллагын хүсэлтээр шинжилгээ хийж явж байгаа. Босого үний хувьд сая бидний тэр яг хяналт үнэлгээний явцад даатгалаас нөгөө 70 хувь хөнгөлдөг 50 хувь хөнгөлдөг гэдэг үнээ ЭМД бууруулчихсан яг тэр цаг үе байсан юм байна лээ.

Тэгээд тэр бид нарын хяналт үнэлгээний явцад манай байгууллага ч гэсэн маш их эмийн өндөр үнэ өндөр байна гэдэг гомдол ирсэн. Энэний дараа бол даатгал бас тэр босго үнээ бууруулсан юм байна лээ тэ. Тэрийг Баярболд дарга нэмж тайлбарлах байх. Тэгэхээр тэрнээс хойш бас яг энэ иргэдийн судалгаагаар тэр эмийн үнэ өссөн гэдэг асуулт бас арай багассан. Тэгэхээр 1 ёсондоо даатгал авч байгаа иргэд дээр эмийн үнэ өндөр байна гэдэг асуудал аягүй их яригддаг юм байна. Тэгээд тэр нөгөө иргэдээс өөрөөс нь гаргах мөнгийг нь өндөр болгочихоор иргэд эм үнэтэй байна гэж үзээд байгаа юм байна гэдэг юм бас бид нарын энэ судалгаанаас харагдаад байгаа юм.

Тэгэхээр сүүлд бид нарын хяналт үнэлгээний дараа даатгал тэр босго үнээ юу нөгөө иргэдээс авах хувиа жоохон багасгачихсан чинь иргэдийн тэр үнэ өндөр байна гэдэг гомдол арай бас багасаад явж байгаа гэсэн үг. Тийм дүн харагдаж байна лээ.

Ж.Чинбүрэн: Жаргалмаа гишүүн тодруулъя. Жаргалмаа гишүүний микрофоныг нээе.

Б.Жаргалмаа: Тийм лабораторийн маань чанар өөрөө хэр олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн байдаг юм бэ гэдгийг би бас дахиад тодруулъя. Тийм лаборатори маань өөрөө яг олон улсын жишгээр тэр

шинжилгээ хийх л лаборатори мөн үү гэвэл хамгийн сүүлд тэгээд дүгнэсэн байдаг юм. Бид нар бас ажлын нөгөө үр дүн даалгавартаа юу оруулсан бэ гэвэл нэмэлт бүтээгдэхүүн буюу нөгөө витамин, амин дэм тэгээд тэд нарыг оруулсан шүү дээ. Тэгээд тэрүүний хяналт ер нь ямар хэмжээнд байна? Иргэдийн хэрэглээ ямар байна? Энэ дээр хяналт тавих боломж нь ер нь хэр байна? Эргээд нөгөөд өөр нэршлийн боловчиг адил үйлчилгээтэй эмийг эмийн даатгалд оруулах ажлыг хийхийн тулд ер нь юу шаардлагатай байна гэж та бүхэн харж байна вэ? Зүгээр Монос, Айвико ч гэдэг юм уу нэг ийм монопол эрхтэй гээд бид нар ингээд орхичихоор нөгөөх чинь давуу эрхээ эдлэх тэр боломжоороо эргээд нөгөө нэг үнэ бүтээгдэхүүнийхээ үнийг нэмэх тэр байдлыг нь бид нар үүсгээд байгаа юм биш үү? Энэ дээр хяналт тавих боломж ер нь хэр байна вэ?

Бид нар эмийн чанар үнээс гадна Монголд үйлдвэрлэж байгаа эмийн бүтээгдэхүүнийхээ нийлүүлэлт дээр.

Ж.Чинбүрэн: Энхтуяа тодорхой шууд хариулаарай. Нуриаа биш. 2 номерын микрофон нээгээрэй.

Д.Энхтуяа: Манай лабораторийн хувьд бол стандарт хэмжил зүйгээр бол нөгөө ISO стандартаа бодвол жил бүр сунгуулаад хамгийн сүүлийн итгэмжлэлээ сая 6 сард хийгдээд сунгуулчихсан байж байгаа. Итгэмжлэлийн хүрээгээрээ бол эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, биологийн идэвхт бүтээгдэхүүний шинжилгээг бүрэн хийх чадвартай. Олон улсын Анабийн итгэмжлэлийг бол өмнө нь авч байсан. Олон улсын итгэмжлэлээ сунгуулж чадаагүй байгаа. Эмийн агентлаг руу шилжиж ирснээсээ хойш ер нь бол яг чин үнэндээ бол манай лабораторийн чадвар муу байгаа. Тоног төхөөрөмж нь Азийн хөгжлийн банкнаас 2013 онд авсан тоног төхөөрөмж нь одоо

хүртэл хэрэглэгдэж байгаа нэлээн удаан хэрэглэгдчихсэн Азийн хөгжлийн банк бол нэлээн санхүүжилтээр манай лабораторийг чадавхжуулж өгсөн. Тэрнээс хойш ерөөсөө ингээд нэмэлт нөгөө апдэйт хийж чадаагүй. Ингээд чадвар нь байхгүй.

Дээр нь нэлээн олон сургагдсан хүний нөөцүүд нь бас гараад гараад явчихсан чадварын асуудал байж байгаа. Гэхдээ бол ямар ч байсан итгэмжлэлийнхээ хүрээн дээр бол шинжилгээнүүдээ хийж байгаа. Олон улсын фармынхаа дагуу шинжилгээнүүдээ хийгээд явж байгаа. Манай агентлаг.

Ж.Чинбүрэн: Минут нэмээрэй 2 номерын микрофон дээр гүйцээж хариулъя.

Д.Энхтуяа: Лабораторио сайжруулах чиглэлээр хүний нөөцөө нэлээн сая гэхэд сүүлийн үед 4, 5 мэргэжилтнүүдийг гадагшаа сургалтад хамрууллаа. Дээр нь дэлхийн эрүүл мэндийн байгууллагууд руу тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийх нэлээн судалгаануудаа хүргүүлчхээд байж байна. Засгийн газар руу бас энэ асуудлаа нэлээн тавьсан байж байгаа. Биологийн идэвхт бүтээгдэхүүний хувьд ер нь сүүлийн үед аягүй их орж ирж байгаа. Яагаад вэ гэхлээр нөгөө зөвшөөрлийн хууль дээр биологийн идэвхт бүтээгдэхүүнийг ханган нийлүүлэх байгууллагын зөвшөөрөлгүй болчихсон зүгээр энгийн аж ахуйн бүртгүүлэх эрхтэй болчихсон, нэгдүгээрт.

Хоёрдугаарт ер нь бол биологийн бүтээгдэхүүнийг Монголчуудын хэрэглээ ихсэж байгаатай холбоотойгоор ялангуяа дээж бүртгэлийн юу аягүй их орж ирж байгаа. Тэгэхээр энэ бол бас манай лаборатори нэлээн ачаалал үүсгэж байгаа. Гэхдээ бид нар нэгэнтээ л биологийн бүтээгдэхүүн гэдэг ангилалд л байх ёстой бол заавал бүртгүүл гэдэг шаардлагыг

тавиад хяналтынхаа явцад хэрвээ таны энэ бүтээгдэхүүн биологийн бүтээгдэхүүн бол бүртгүүл гээд бас арга хэмжээгээ аваад байна. Тэгээд ер нь бол бид хэд нөгөө эмийн бүтээгдэхүүнийхээ үнийг тэр үнийн холбоотой тэр нөгөө давамгай байдалтай холбоотой юмыг бол шударга өрсөлдөөнөөс харуулах байх гэж бодож байна.

Ж.Чинбүрэн: Тэрбиш зар сурталчилгааны газрын дарга нэг номерын микрофоныг нээчихье. Жаргалмаа гишүүний асуултад хариулъя.

Ц.Тэрбиш: Ер нь сая бид нар яах вэ? Хоёрхон үндэслэлээр илүү нарийвчилж шалгалт хийгээд ингээд хариуцлага ноогдуулсан байгаа. Цаашид бол илүү нарийвчлал дахиад судалгаа хийгээд яг тэр өнчин эм гэдэг юм уу яг өндөр өртөгтэй эм гэдэг юм уу эм тус бүрээр нь өшөө илүү нарийвчлалтай ийм монопол компани тогтоох судалгаа хийгээд цаашид бас илүү нарийвчлалтай ийм шалгалтыг хийж хариуцлага бас ийм ярих ийм шаардлага үүсэж байгаа. Тэгээд ер нь цаашидаа бас бид нар энэ судалгааг үргэлжлүүлээд хийхээр төлөвлөөд ажиллаж байгаа.

Ж.Чинбүрэн: Бейсен гишүүн асуулт асууя. Бейсен гишүүний микрофоныг нээе.

Б.Бейсен: Энэ яах аргагүй тулгамдсан асуудал хэлэлцэгдэж байна л даа, нэгдүгээрт энэ эм ханган нийлүүлэх байгууллага үүсээд 100 жил болоход манайх дотоодын эм үйлдвэр 29-өөс 30 гэдэг чинь арай хангалтгүй асуудал байж байна.

Тийм учраас энэ сая эмийн үйлдвэрүүдээр очиход ер нь дотооддоо антибиотик платформтай зүгээр шахмал таблет гаргаж байгаа л даа. Энийг үйлдвэрлэх хүчин чадал нь байгаа болов уу? Ер нь тоног төхөөрөмж нь байгаа болов уу энэ талаар судалсан уу? Энэтэй

холбоотой энэ антибиотикийн хэчнээн хувийг гадаад орноос авч байна. Ямар ямар улсаас авч байгаа бол. Жишээлбэл Хятадаас хэдийг нь авч байгаа энэ талаар судалсан судалгаа байна уу, нэгдүгээрт.

Хоёрдугаарт энэ эмийн үнийн өсөлттэй холбоотой энэ 100 төгрөгөөс 209 төгрөг нэмэгдэж байна гэж ярьж байна. Энэ зүгээр таблетка юм уу трупэд нэмсэн үнэ үү? Хайрцагаар нь нэмсэн үнэ үү? Энэ арай бага дүн гарч байна л даа. Тэгэхээр чинь энэ чинь одоогийн харж байхад эмийн үнэ нь нэлээн нэмэгдсэн байгаа шүү дээ. Энэ яаж судалгаа гаргасан юм бол оо? Үүнтэй холбоотой түрүүн танаас өмнө нөгөө Нарантуяа захирлын үед бид нарт гаргаж өгсөн дээр чинь дараалсан 3 НӨАТ төлж байгаа гэсэн байхгүй юу. Гааль дээр 10 хувийн НӨАТ ханган нийлүүлэлт байгаад дахиад 10 хувийн НӨАТ, эмийн сангууд дахиад 10 хувийн НӨАТ-аа 30 хувь нэмж байна гээд бид нарт юм гаргаж өгсөн юм. Та энэ дээр гаргаж өгөхдөө борлуулалтын нийтдээ аравхан хувь гээд тэгсэн байна.

Тэгэхээр чинь дараалсан 30 хувийн НӨАТ байгаа биз. Энийг судалсан уу? Энэ Үндэсний аюулгүй байдалтай холбоотой бас эмийн шинжилгээний лаборатори дээр бид нар очсон. Зарим тоног төхөөрөмж нь байхгүй байсан. Бид нар халти л очоод нэг цаг болоод явсан л даа. Тэгээд стандарт бодисууд нь бас ингээд тус байдаггүй нэг юмаа бичсэн бас бохир тийм юм байсан. Тэр үйлдвэр дээр нь очсон шүү бид нар. Учрал гишүүнтэй бид нар хамтраад очсон. Энэ тал дээр хүчин чадал нь ямар байна. Тоног төхөөрөмж нь шинжилгээ хийх боломж нь байгаа болов уу? Мэргэжлийн хангалт ямар байна энэ тал дээр. Энэ тендерийн юмны асуудал байна л даа.

Эмийн хадгалалт хамгаалалтын асуудалтай ч холбоотой байж болно. Сая нөгөө эмнэлэг дээр гарсан 17 хүүхэд яалаа гэхэд энийг сая эмнэлгүүдээр нь яг явж

шалгасан уу? Жишээлбэл тухайн эмнэлгийн чанарын менежер, эм хариуцсан мэргэжилтэн, сувилахуйн алба бол 7 хоногийн бүх найруулах эм энэ тэрийг нь шалгаад дараагийн 7 хоногийн 5 дахь өдөр бүгдийг нь шалгах ёстой. Зөвхөн сувилагч нар биш гэхэд болохгүй байх. Энэ талын асуудлыг сувилагч дутагдалтай байна нөхөж ажиллаж байна, заримыг нь цалин өгөөд ингээд ажиллуулж байна. Найруулж байгаа юм нь жишээлбэл 09 натриар найруулсан байна уу? Тарилга усаар найруулсан байна уу, 025-ын Новкинаар найруулсан байна уу гээд. Энэ хайлах асуудал нь новкин дээр хурдан байгаа юм. 09-ийн натри дээр бас удаан. Тарилга бус дээр бас удаан хаялдаг байхгүй юу. Энэ асуудал энийг судалсан уу? Чухам тэр эмийн сая гаж нөлөө гаргахад тэр шинжлэх чадвар тэр лабораторит нь байна уу? Энэ талаар асууя. Дараа нь тодруулъя.

Ж.Чинбүрэн: 2 номерын микрофон.

Д.Энхтуяа: Баярлалаа. Бейсен гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр ерөнхийдөө бол эмийн үйлдвэрүүдэд манай дээр эмийн 25 үйлдвэр яг эмийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа. Эдгээр эмүүдийнх нь үйлдвэрүүдийн маань 9 үйлдвэр бол GPS-ийн шаардлага хангасан үйлдвэрүүд. Тэгэхээр нийт энэ үйлдвэрүүд бол нийт дотоодын эмийн үйлдвэрүүдийн 80 хүртэл хувийн эмийг хангаж байгаа. Тэгэхээр GPS-ээ авсан үйлдвэрүүд маань антибиотик, эм, шахмал, эмийн хэлбэрээр тарилгын эмийн хэлбэрийг үйлдвэрлэх тодорхой хэмжээний хүчин чадалтай болчихсон гэж бас үзэж болно. Бас үйлдвэрүүд өөрсдийнхөө хүчин чадлыг сайжруулаад өөрсдөө GP-ийнхээ дагуу бүтээгдэхүүн түүхий эдээ татан аваад бүтээгдэхүүнээ тоног төхөөрөмжид суурилуулаад үйл ажиллагаа явуулаад

хүмүүсээ сургаад ингээд зөвлөхүүдээ аваад бас ажиллаж байгаа.

Тэгэхээр энэ үйлдвэрийн хувьд бас хүчин чадал байгаа гэж үзэж болно оо. Тэр юуны эмийн тэр саяын тэр 17 хүүхдийн юутай холбоотой асуудлыг ЭМЯ-наас ажлын хэсэг гараад шалгаж хяналт шалгалт хийж байгаа. Энэ ажлын хэсэг дотор манайхаас байцаагч нар ороод ажиллаж байгаа. Дээр нь тэр эмнэлэг дээр хэрэглэсэн эм, найруулсан бүтээгдэхүүн, хэрэглэсэн тарилгын уусмал шингэнүүд антибиотикүүдийг бүгдийг нь шинжилгээндээ хамруулчихсан. Манайх яг энэ шаардлагатай шинжилгээнүүдийг бодвол яг хийгээд маргаашаас ер нь эхний шинжилгээний хариунууд гараад эхэлчихнэ.

Тэгэхээр тодорхой хэмжээгээр энэ дээрээ бас хариугаа гаргачихна гэж үзэж байгаа. Тэр эмнэлгүүд дээр байгаа хяналтын хувьд бол тэр чанарын алба, эм зүйн алба, сувилахуйн албан дээр нөгөө эмнэлгийнхээ бүтэц үйл ажиллагааны стандартын дагуу үйл ажиллагаа явуулж байгаа эсэх энэ сувилагчийн үүрэг чиглэл өгсөн хяналт үнэлгээ хийсэн байдал бол хяналт үнэлгээгээр давхар гараад ирнэ. Энэ хяналтын явцад хийгдэж байгаа асуудал байж байгаа.

Лабораторийн хувьд манайх хүчин чадлын хувьд ямар ч байсан жилдээ 2 мянга гаруй эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд биологийн идэвхт бүтээгдэхүүнийг шинжилгээнд хамруулж байгаа. Тэгэхээр ямар ч байсан одоо нэг тодорхой нэрийн эмнэлгийн лабораторийнхоо тоног төхөөрөмжөө сайжруулаад бас нэлээн хэдэн нэр төрлийн стандарт бодис уусмалуудаа авчихсан тохиолдолд манайх нэг ямар ч байсан олон улсын стандартын дагуу шинжилгээнүүдийг хийгээд байх боломж бүрдэх юм байгаа юм. Тэгэхээр ямар ч байсан ойрын үед бас шаардлагатай хийх

ёстой ажлуудаа бид хэд хийгээд явж байгаа.

Эмийн үнийн бүрдэлтийн хувьд манай Хулан чинь нэмэлтээр нэг хэлээдэх дээ. Энэ нөгөө нэг юун дээр шахмал нөгөө нэг шахмалаар юугаар нь тооцсон гэдэг юм саяын таблет гэхээр, труп гэхээр гэдгийг нь нэг.

Ж.Чинбүрэн: 1 номерын микрофоныг нээж өгье.

Д.Энхтуяа: Манай нөгөө яг үнийн судалгаан дээр ажилласан мэргэжилтэн энэ дээр бас бид нар нэмж.

Ж.Чинбүрэн: Нэг номерын микрофон дээр.

Г.Хулан: Энэ эмийн үнийн хяналт шалгалт дээр үнийн асуудлыг тооцоолохдоо шахмал бүр дээр гаргасан. Тэгээд тэр нөгөө гааль НӨАТ-ын татварын асуудал дээр бас хариулт хэлье.

Ерөнхийдөө нөгөө тухайн эмийн бүтээгдэхүүн хил дээр орж ирэхдээ гаалийн 5 хувь, НӨАТ-ын 10 хувийн татвар төлдөг. Тэгээд тухайн эм ханган нийлүүлэх байгууллага маань борлуулалт хийх үедээ 10 хувиа буцааж авдаг. Ингээд эмийн сан юм уу, эрүүл мэндийн байгууллагууд руу түгээлтээ хийдэг. Эмийн сан дээр бол бас яг эцсийн хэрэглэгчид борлуулахдаа 10 хувийн НӨАТ нэмж борлуулдаг.

Тэгэхээр ерөнхийдөө яг тухайн өртгийн тооцоолол хийгээд үзэхэд бол эмийн сан болон эм ханган нийлүүлэх байгууллагуудын НӨАТ бол буцаагаад авчихдаг учраас өртөгт шингэдэггүй. Өртөгт юу шингэдэг вэ гэхээр тухайн импортын эмийн хувьд бол тухайн нэхэмжлэлийн үнэ буюу гэрээний үнэ. Энэ дээр гаалийн татвар нэмэгдэнэ. Тэгээд үйл ажиллагааны зардал нэмэгдэнэ. Тодорхой хэмжээний ашиг нэмэгдэнэ. Ингээд эцсийн

хэрэглэгч бол яг энэ өртөг шингэсэн үнэ дээр 10 хувь нэмж борлуулдаг. Тэгэхээр ерөнхийдөө энэ нэмэгдсэн өртгийн албан татварын хувьд эцсийн хэрэглэгч төлнө. Гаалийн татвар гээд нийтдээ 15 хувь эмийн үнэд нэмэгдэж ордог байгаа.

Ж.Чинбүрэн: Бейсен гишүүний микрофоныг нээе. Нэмж тодруулъя.

Б.Бейсен: Сая би нөгөө энэ гааль дээр чинь 117 төгрөг гээд ярьж байна тэ. Энэ чинь тэгээд таблет дээр юм уу, труп дээр нөгөө хайрцагар нэмсэн үү гээд асуусан. Энэ талаар тодорхой хариулт авъя 1 дүгээрт.

Хоёрдугаарт энэ эмийн санд жишээлбэл одоо гератон гэхэд хуучин 10 хэдэн мянга байсан бол одоо хорин хэдэн мянга болчихсон шүү дээ бараг. Бараг зуун хэдэн хувь нэмэгдчихсэн тийм зарим нь 200 хувь нэмэгдчихсэн байгаа. Энэ талаар шалгасан уу гээд асууж байна.

Дараагийн асуудал энэ эмийн тоног төхөөрөмжийн хангалт, лабораторийн тоног төхөөрөмжийн хангалт муу байна л даа. Яг нарийн хийж чадах юм уу манайхан ерөөсөө энэ талаар. Одоо тэгээд ямар тоног төхөөрөмж хангалттай байна тэр талаар та үзсэн үү? Ер нь. Тэгэхгүй бол энэ чинь үндэсний аюулгүй байдалтай холбоотой чанартай тийм лабораторитой байх ёстой л доо. Бид нар энэ талаар асууя.

Ж.Чинбүрэн: Энхтуяа дарга үгүй тэгээд 2013 оноос хойш юугаа хийж байсан юм бэ? Энэ чинь 10 жил болж байхад эмийн чанараа шалгаж чаддаггүй та хэд 2022 онд агентлаг байгуулагдсан. Энэ лаборатори та хэд дээр хэдэн онд очсон юм тэгээд? Энэ төсөвтөө ер нь яаж сууж байгаа юм? Ялангуяа энэ эмийг шалгахад гарч байгаа зардлуудаа яах юм. Энэ чинь нөгөө та хэдийн ажлын төсөв чинь орсон юм уу? Зөвхөн бид энэ хянан

шалгах түр хороогоороо эмийн чанарыг шалгая гээд зах зээл дээр байгаа эмүүдээ санамсаргүй төлөвлөлт авъя гэхэд л зөвхөн худалдаж авахад л 6 сая төгрөг хэрэгтэй байна шүү дээ.

Тэгээд дээрээс нь чанар шалгана гэхлээр хэдэн төгрөг гарах юм тэ? Тэгэхээр та бүхэн энэ урсгал зардалд энэ төсөв чинь ер нь ордог юм уу? Энийгээ хийх боломж нь байгаа юм уу?

Энэнд хариулаач 2 номерын микрофон Энхтуяа.

Д.Энхтуяа: Лабораторийн хувьд бол 2022 оны 1 сараас эмийн агентлаг дээр шилжиж ирсэн юм. МХЕГ-ын харьяанд үйл ажиллагаа явуулж байсан. Тэгээд ер нь бол энэ нөгөө төрийн хяналт шалгалтын хуулиараа хяналт шалгалтыг хийхэд бүтээгдэхүүнийг худалдаж авах шинжилгээний зардал гээд энэ зардлуудыг бол өмнө нь төсөв дээр ерөөсөө төсөв ялангуяа агентлагийн төсөв дээр ерөөсөө мөнгө төсөв байгаад байгаагүй. Энэ жилийн хувьд бид нар лабораториудыг лабораторио шинэчлэх тэгээд хяналт шалгалтын дээж нь дээж худалдан авч шинжилгээнд хийх зардлуудыг төсөвтөө тусгуулаад дараагийн жилүүдээс ингээд үе шаттайгаар нэмээд явахаар жишээлэх юм бол манай хяналт шалгалтад шаардлагатай дээжээ авахад байцаагч нарын авдаг дээж мөн тандалт судалгааны дээжийг авахад гээд ерөнхий бид нар судалгаа гаргаад, юу гаргаад энэ дүн дээрээ бол нэг эхний байдлаар 50 сая төгрөг төлөвлөсөн.

Тэгэхдээ бол энэ бас яг шууд батлагдаад бид нарт шууд ирнэ гэдэг бол бас магадлал багатай эрсдэлтэй л юм байгаа юм.

Ж.Чинбүрэн: Болно. Батлут гишүүн асуултаа асууя.

Д.Батлут: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе ээ.

Нийгэмд тулгамдаж байгаа маш чухал асуудлыг шалгах Түр хороо байгуулагдаад ажиллаж байгаа. Эмийн хянан шалгах түр хороо бид нар бодит байдалтай нүүр тулж байгаад л гарц гаргалгаа зөв шийдлээ л олж авах гээд байгаа юм. Би тэгж ойлгож байгаа. Тэгээд би та бүхний гаргаж ирсэн ажилласан энэ тайлан мэдээлэл дундаас чинь асуулт асуух гэж байна.

Эмийн үнийн өсөлттэй холбоотой асуудлыг дурджээ. Иргэд бол 31.2 хувь нь хэт үнэтэй, 42 хувь нь үнэтэй байна гээд гаргачихсан байна. Эмийн жижиглэнгийн үнэ өсөлтөд хамрагдсан эмийн 45 хувь нь үнэ нэмэгдсэн байна гээд та нар бас тайландаа тусгачхаж. Нэг ёсондоо та нар ч гэсэн үнэ нэмэгдсэнийг хүлээн зөвшөөрсөн байна. Иргэд ч гэсэн бас үнэ нэмэгдсэн хэт өндөр үнэтэй байна гээд ингээд тайлан дээр гарч ирчхээд байгаа байхгүй юу. Тэгээд энэ зүйлүүд дээр хэрхэн анализ хийсэн юм бэ гэдгийг нь би та бүхнээс асуух гээд байгаа юм. Эмийн үнэ өсөлтөд нөлөөлж буй хүчин зүйл гээд эм ханган нийлүүлэх байгууллагын мэргэжилтнүүд гаргасан байна л даа. Хадгалалт агуулах гэх мэт бусад зүйл нөлөөлж байна гэж 3-аас 37 хүртэлх хувь нь үзсэн байна. Энэний зааг ялгаа яг юунаас шалтгаалчхаад байгаа юм бэ? Яагаад зарим нь 3 хувь гэж үзээд байгаа юм. Яагаад зарим нь 37 хувь гэж үзээд байгаа юм.

Тээвэрлэлтийн зардалд 7-гоос 30 хувь гэсэн байгаа юм. Ямар нь 7 хувь гэж үзээд байгаа юм. Ямар нь 30 хувь гэж үзээд байгаа юм бэ? Валютын ханшийн зөрөө 2-оос 53 хувийн зөрөө гарч байна гэсэн. Яагаад 2 хувийн.

Ямар нь яагаад зарим нь 53 хувь гэж үзээд байгаа юм бэ? Би нийтлэг л авч

үзсэн байх гэж харж байгаа шүү. Үйлдвэрлэгчийн үнийн өсөлтөд 5-аас 35 хувь нөлөөлсөн байна гэж. Энийг хэн тогтоогоод байгаа юм бэ? Манайхан яг энэ тал дээр ажилласан ажиллагаа байна уу? Тухайлбал яг тухайн үйлдвэрлэгчээс гаднын ч юм уу, дотоодын ч юм уу үйлдвэрлэгч нь ингэж ингэж нөлөөлсөн байна гэж.

Тэгэхээр энэ бол эм ханган нийлүүлэх байгууллагын мэргэжилтнүүд өөрсдийнхөө судалгаа ч гэдэг юм уу бас нийлүүлж байгаа нөхцөл байдлуудаас харж дүгнэсэн дүгнэлтээ гаргаж байна гэж харж байгаа юм. Тэрийг та нар олж авсан байна. Энэ зааг ялгаанууд ямар учир шалтгаанаас ийм өндөр зөрөөтэй гараад байгаа юм бэ? Их хол зөрөөтэй үнийн өсөлт нь нөлөөлж байна гэж үзээд байгаа юм бэ гэдэг дээр надад хариулт өгөөч ээ.

Хоёрдугаарт нь эмийн чанартай холбоотой асуудал маш чухал. Иргэдийн судалгаанд хамрагдсан иргэдийн 64 орчим хувь нь эм бол чанартай байна.

4.9 хувь нь чанаргүй, 31 хувь нь мэдэхгүй гээд хариулчихсан. 668 иргэн орсон юм байна л даа. Тэгээд төр бас нэг доройтсоны хэлбэр л дээ. Яг үнэндээ эмийн чанартай эсэхийг бид нар өөрсдөө шийдэж чадахгүйгээр иргэдээсээ асуугаад байж байна гэдэг бол үнэндээ би хэлж мэдэхгүй байна. Нэг хов жив баздаг айлын авгай шиг л сонсогдоно. Мэргэжлийн байгууллагынхаан. Тэгээд ийм байж байж бид нар тэгээд ажлын хэсэг гарчхаад ийм зүйл дээр дүгнэлт хийж байна гэвэл ёстой уучлаарай. Би магадгүй тийм шинжлэх ухаанч, лабораторийн тодорхой дүгнэлтүүд эм болгон дээр ч гэдэг юм уу гарч ирэх ёстой гэж харж байсан.

Тэгэхээр энэ асуудал яригдахгүй бол зүгээр магадгүй эм ханган нийлүүлэх байгууллагын ажилтан, эмнэлгийн ажилтан, албан хаагчид иргэдээс санал

асуулга хэлбэрээр авчхаад тэрийгээ бид нар ингээд тайлан гээд сонсгоод байж байгаа нь харамсалтай байна аа. Тэр доройтсон байна шүү. Та бүхний арга барил бас өөр болчихжээ биш байна гэж хэлэх гээд байгаа юм. Тэгээд энэ дээр надад нэг хариултууд өгөөч.

Ж.Чинбүрэн: Хариултаа хаанаас эхлэх вэ? 2 дугаар микрофон. Эм эмнэлгийн хэрэгслийн зохицуулах Энхтуяа.

Д.Энхтуяа: Баярлалаа. Батлут гишүүний асуултад хариулъя.

Эмийн үнийн өсөлттэй холбоотой ерөнхийдөө бол бас манай хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль бусад хуулиуд дээр бол эмийн үнэтэй холбоотой зохицуулалт нэлээн бүрхэг тодорхой биш байдаг. Тийм учраас ерөнхийдөө бид нар энэ хяналт үнэлгээнийхээ явцад бас энэ үнийг ингээд тодорхой нэрийн эмүүдээ сонгоод судалгаагаа хийгээд энэ судалгаан дээрээ үндэслээд цаашидаа бас зохицуулалтыг хийж байж энэнийхээ дагуу үйл ажиллагаагаа чиглүүлж явах нь зөв байна гэж үзсэн байгаа. Тэгээд ерөнхийдөө эмийн сангууд дээр түрүүний үнэлгээнд дурдсан тэр 45 хувь хүртэлх хувь нэмж байна гэдэг нь бол тэр нийт анхны авсан үнээсээ бол иргэдийн гар дээр очиход тийм үнэ нэмэгдэж байна гэсэн дүн харагдаж байгаа.

Тэгэхээр энэ дээр тэр иргэдийн асуумж дээр хэлсэн тэр саналуудын хувьд авч үзэх юм бол ер нь эм гэдэг бол яг тухайн хүнд үйлчлээд хэрэглэж байгаа тохиолдолд бол зохистой хэрэглээний асуудал асуудал маш чухал байдаг. Тэгэхээр эмийг бол зөв хадгалж, зөв зохистой хэрэглэсний үндсэн дээр тухайн эм маань яг тохирсон таарсан үйлчилгээгээ үзүүлнэ. Тэгэхдээ тухайн хүний биеийн онцлог эрүүл мэндийн байдлын шалтгаанаас хамаарахаас гадна

тухайн хүний давхар хэрэглэж байгаа эм давхар хэрэглэж байгаа хүнстэй маш хамааралтай байдаг.

Тэгэхээр энэ хадгалалтын дэглэм зохистой хэрэглээний асуудлыг иргэдийн мэдлэг хандлага ямархуу байгаа вэ гэдгийг бас энэ дээрээсээ авахыг үзсэн байж байгаа.

Тэр тээвэрлэлтийн 7-гоос 30 хүртэл хувь гэдэг бол тэр байгууллагуудын өөрсдийнх нь хэлсэн асуумж бол ер нь бол энэ сүүлийн 2, 3 жил ковидтой холбоотой нэлээн энэ байгууллагууд өөрсдөө энэ асуумжид ийм ярилцлагын үед ч гэсэн ийм асуудлууд ярьж байгаа. Энэ бол ковидын үеийн тээвэрлэлт үнийн өсөлт буурахгүй байна.

Дээр нь валютын ханшийн зөрөө гэдэг нь бол компани болгоны энэнээс гадна эм болгон дээрээ харилцан адилгүй байгаа учраас бас энэ дүн ингэж гарч ирсэн байгаа юм аа. Үйлдвэрийн эмийн үнийн өсөлтийн хувьд мөн адилхан тэр нөгөө гол нь үйлдвэр дээр түүхий эдээс гадна сав баглаа боодол хаяг шошгын асуудал байдаг.

Тэгэхээр энэ манайх ихэвчлэн дандаа импортлогч улс учраас бүх түүхий эд сав баглаа боодол дандаа ихэвчлэн импортоор авч байгаа. Энэ тохиолдолд сав баглаа боодолын үнэ бол бас хамгийн өндөр байр суурьтай байгаад байгаа гэдэг нь манай судалгаан дээрээс бас гарч юу асуумж дээрээс гарч ирсэн. Эмийн үнийн өсөлтийн хувьд мөн адилхан. Үйлдвэрүүд дээрээ ихэвчлэн импортоор авч байгаа учраас эм үйлдвэрүүд дээр дотоодын үйлдвэр дээр бол үнийн өсөлт нэлээн өндөр байгаа нь бас харагдсан байж байгаа.

Тэр эмийн одоо яг судалгааны хувьд бол би түрүүн бас хэлсэн. Яг лабораторийн хувьд бид нарын энэ удирдамжийн хугацаа бол цөөхөн,

хугацааны хувьд аягүй давчуу шийдвэр гаргах гэсэн зөвлөмж чиглэл байсан учраас бид хэд яг энэ хяналт үнэлгээнийхээ явцад бол бүтээгдэхүүний дээжид аваагүй юм байгаа юм. Түүнээс биш тандалт болоод хяналтынхаа явцад манайхан дээжээ аваад шинжилгээндээ хамруулаад явж байгаа.

Ж.Чинбүрэн: Батлут гишүүн тодруулж асууя. Батлут гишүүний микрофоныг нээе.

Д.Батлут: Хариулж байгаа одоо манай энэ нэг төрийн байгууллагынхан нэг ийм байдалд сурчхаад байгаа юм. Нөгөө хугацаа нь 4 минут байдаг учраас нэг тойруулсхийсээр байгаад л нэг тэгээд хугацаагаа өнгөрөөчих гээд байгаа юм. Таны хариулт ерөөсөө байгаа оносон ч үгүй. Би тодорхой асуулт асуусан. Тэгээд иймэрхүү байдлаар формаль юм хийхээ больчих. Энэ нөхдүүдийг болиулчихмаар ч юм уу хаашаа юм бэ? Яамаар юм бэ? Та нар ингэж ажиллажхаад энэ үнийн өсөлттэй холбоотой ажлын хэсгийг мэдээллээр хангаад эндээс үр дүн гарна гэвэл ёстой лөөлөө за юу. Энэ шударга өрсөлдөөнийхөн та нар энэ дээр ажилла л даа. Энэ чинь та нарын хийх ёстой бас ажлын нэг хэсэг мөн шүү дээ.

Хадгалалт агуулах 3-аас 37 хувийн зөрөөтэй мэдээллүүд өгсөн байна. Валютын хани 2-оос 53 хувийн зөрөөтэй. Үйлдвэрлэгчийн үнийн өсөлт 5-35 хувийн, тээвэрлэлтийн зардал нь 7-гоос 30 хувь. Асар хол зөрөөтэй ийм мэдээллүүд

Ж.Чинбүрэн: Батлут гишүүнд нэмэлт хугацаа өгье. Микрофоныг нь өгье.

Д.Батлут: Тэгээд асар их зөрөөтэй ийм мэдээллүүд өгөөд байгаа байхгүй юу. Тэгээд энэ дээр чинь нөгөө нэг эмийн үнийн зохиомол хөөсрөлт чинь яваад байна шүү дээ. Би тэгж харж байна. Энийгээ та нар яг бодитой юм уу, бодитой бол яг ийм

нөхцөл байдлууд байгаа юм уу, үгүй юу гэдгийг нь гаргаж ирээч ээ. Эндээс харах юм бол нэлээн их өндөр өсөлтүүд бий болох нөхцөл байдлууд үүсчихсэн байна шүү дээ. Энэ мэдээллүүдээ социализмын үед нэг зураг авалт гэж хийдэг байсан юм шүү дээ. Та нар санадаг бол тийм ээ, бодит өртөг тогтоодог.

Үгүй яагаад ийм зүйл дээр ажиллагаа хийж болохгүй байгаа юм бэ? Энийгээ анхаараач.

Тэгээд 2 дугаарт нь чанар гэнгүүт тэгээд юу ч хариулаад байгаа юм бүү мэд байна. Иргэдийн өөрсдөө эм ууж үзээд ингээд л шинжлээд яг үзүүлэхэд нь энэ чинь ёстой чанартай байна гээд гараад ирдэг тийм үзүүлэлт ухаалаг болчихсон юм бол та тэгээд бид нар итгэлтэй л байна. Тийм зүйл байхгүй. Тэр лабораторийнхоо үзлэг шинжилгээгээр хийдэг, цаашидаа тэр нь лаборатори хүчин чадал нь хүрдэггүй юм бол.

Ж.Чинбүрэн: Батлут гишүүнд дахиад минут сунгая.

Д.Батлут: Лабораторийнхоо хүчин чадлыг нэмэгдүүлдэг барьдаг тэр хөрөнгө оруулалтын асуудал энэ тэрээ уул нь яг энэ ажлын хэсэг Түр хороон дээр ингээд тавиад явж байх ёстой байхгүй юу. Бид нар ингэлээ ингэлээ бодит байдалд нь. Ийм нөхцөл байдалд болоод бид нар ингэж чадсангүй гээд. Тэгэхгүй чанарын асуудал гэнгүүт эмнэлэгт ажилладаг хүмүүсээс, аптект ажилладаг хүмүүсээс иргэдээс чанартай байна уу, үгүй юу гэж асуумжаар асуучхаад тэрийгээ энэ дотор оруулж ирээд бидний толгойг угаана гэж байгаа бол уучлаарай та нар, муу байна. Наад арга барил чинь ч биш байна. Ингэж ч ажиллаж дүгнэлт гаргаж энэ ажлын түр хороо дүгнэлт гаргаад цааш нь Их Хурал, Засгийн газарт чиглэл өгнө гэвэл тэрэн шиг худлаа юм байхгүй шүү. Ингэж амьдралаас тасарсан юмнууд мэдээллээр

хангадаг байдал чинь өнөөдөр биднийг ажлаа зөв төлөвлөж, ажлаа зөв хийж чадах боломжийг бүрдүүлж өгөхгүй байгаа больцгооё энэ байдлуудаа. Энэ шударга өрсөлдөөнийхөн ч гэсэн энэ ажлын хэсгийнхэн ч гэсэн хамтарч ажиллах хэрэгтэй шүү дээ. Энэ дээрээ ийм олон асуудлууд гарч ирчхээд байхад чинь та нар өнөөдөр формалный мэдээллүүд оруулж ирчхээд бид нарын толгойг угаана гэж байгаа бол тэрэн шиг худлаа зүйл байхгүй шүү.

Дараа нь үг хэлнэ. Баярлалаа.

Ж.Чинбүрэн: Сандаг-Очир гишүүн асуулт асуу гэхээсээ илүүтэйгээр бас саналаа л хэлье гэж бодож байна. Тэгээд энэ манай ажлын хэсэг Шадар сайдын, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар олгогдсон ажлын хэсэг хяналт шалгалт, үнэлгээ хийсэн юм байна тэгээд бас хугацаа юм тулгамдуу байсан эд нар гэж ярьж байх шиг байна. Тэгээд бид нар өвчнийхөө оношийг зөв оношилж байж л эмчилгээ шийдлээ л ярих байх л даа. Тэгээд өнөөдөр Монгол Улсад бид нар нэг асуудлаа мэдээд байгаа юм шиг хэр нь мэдэхгүй ч байгаа юм шиг бүгдээрээ хараад байгаа шүү дээ. Эм үнэтэй байгаа юу? Үнэтэй байгаа. Гааль хяналтын байгууллагаар хяналтгүй орж ирж байгаа юу гэвэл орж ирж байгааг мэдсээр байгаа. монопол байгаа юу гэвэл байгаа.

Салбарынхан болоод улс төрд нөлөө бүхий улсууд энэ чиглэлийн бизнестэй холбоотой юу? Хамаарал бүхий байгаа юу гэвэл байгаа. Энийг мэдсээр байгаа. Тэгээд бид нар ер нь цаашидаа эмийг хямдруулна гэж үзэх юм уу? Эмийг чанаржуулъя гэж ярих юм уу? Орж ирж байгаа импортоор орж ирж байгаа эмийг. Иргэд бол одоо хэдийгээр сард орлогоосоо бараг 100 гаруй мянган цаасаар эмийн худалдан авалт хийж байна гэж байна. Энэ бага хэмжээ нь л байх л даа. Тэгээд энэ авч байгаа эм нь болохоор даруй гаалиар орж ирснээсээ 2

дахин 2-оос 3 дахин нэмүү өртгөөр орж ирж байна. Нэмэгдсэн үнэ тарифтай.

Харамсалтай нь энэндээ тарсан чанартай эм хэрэглэхгүй байгаад л асуудлын гол нь байгаа юм. Асуудлын гол нь. Монголд эм одоо сүүлдээ бүүр ингээд эмч нар чинь бүүр өөрсдөө энийгээ мэддэг болчихсон. Эмийгээ болохоор Монголд зарагдаж байгаа эмээс илүүтэй Солонгос, Япон руу, Турк руу энэ эмийг нь арай илүү үйлчилгээтэй шүү гэж ингэж өөрсдөө зөвлөдөг болчихсон байна шүү дээ.

Тэгэхээр энэ чинь цаанаа өөрсдөө Монголд зарагдаж байгаа импортоор орж ирж байгаа эмийн чанаргүй байдлыг үндсэндээ хүлээн зөвшөөрч байгаатай адилхан. Хүлээн зөвшөөрч байгаатай адил. Хамгийн бага тунтай чанар муутай эмүүдийг оруулж ирээд 2-оос 3 дахин өндөр үнэтэй зараад байгаад л асуудлын гол нь байна. Тэгээд энийг хэн хийгээд байна вэ? Эм өөрөө үндэсний аюулгүй байдлын хэмжээний асуудал мөн үү? Бүтээгдэхүүн мөн үү? Хяналтад байх ёстой юу? Тэгэхээр та бүхний маань энэ хянасан хийсэн хяналт шалгалтын дүн цаашид авах арга хэмжээ гээд ингээд яг энүүгээр ажлын хэсэг ингээд би бол ингээд цаашидаа ярилцаж байгаад ингээд ажлын хэсэг тогтоол гаргах байх. Тогтоолын хэмжээнд асуудлыг боловсруулж Улсын Их Хурлаар хэлэлцэж шийдвэр гаргах байх гэж бодож байгаа юм. Эцсийн дүндээ. Тэрний урьд талд бэлтгэл ажил хяналт шалгалтын хувьд хийгдэж байгаа гэж ойлгож байгаа. Тэгэхээр яг та бүхний энэ оруулж ирж байгаа мэргэжлийн салбарынхны, хийсэн хяналт шинжилгээ мэргэжлийн байгууллагуудын хийсэн энэ хяналт шинжилгээ яг эцсийн дүндээ энэ чиглэлээр Улсын Их Хурлын тогтоолын заалт болоод явахад эцсийн үр дүн бид нарын тавьсан зорилго биелэгдэхээр байна уу, үгүй юу. Оруулж ирж байгаа ийм хяналт шалгалт сайжрахаар байна уу? Чанартай болохоор байна уу гэдгээ нэг та

бүхэн эргээд хараадхаач. Та бүхнийг энэ оруулж ирж байгаад цаашид авах арга хэмжээний чиглэлээр энэ арга хэмжээнүүдийг авчихъя гэж бодъё хэрэгжүүлье гэж бодъё.

Тэгвэл одоо Монголд зарагдаж байгаа импортоор орж ирж байгаа хэрэглэгдэж байгаа эмүүд чанартай байн уу.

Ж.Чинбүрэн: Асуултад хариулъя. 2 номерын микрофоныг нээе.

Д.Энхтуяа: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя.

Бас гол зөв асуудал хөндлөө. Энэ ер нь эмийн нөгөө чанар үйлчилгээний асуудал ярихад яах аргагүй эмийн сонголт эм бичиж байгаа эмчийн эмийн сонголт мөн эмийн хадгалалтын асуудал зайлшгүй байдаг. Тэгэхээр ер нь манайх агентлагийн хувьд яах вэ тандалт судалгааг нэлээн эмнэлэг рүү чиглээд сүүлийн үед хийж байгаа. Яг тэр эмч нарын эмийн бичилт эмийн сонголт дээр бас нэлээн үйл ажиллагаагаа явуулаад энэ цаашидаа сайжруулъя гэдэг дээр явж байгаа. Ер нь бол бид хэд энэ хяналт үнэлгээний явцдаа бол түрүүн хэлсэн тодорхой бас давчуу байсан учраас гэдэг тайлбар хэлэх нь зүйтэй байх. Тэгэхдээ бид хэд энэ хүрээндээ бол хамгийн гол номер нэг асуудал яах аргагүй эрх зүйн зохицуулалт чухал юм байна гэдэг асуудал.

Дээр нь яг энэ цахим тогтолцооны асуудал бас манай салбарт зайлшгүй байна аа. Ер нь энэ бол маш олон жилийн өмнө бас эрүүл мэндийн салбарт яригдаж байгаа асуудал. Тухайлах юм бол гаалиар энэ эм орж ирлээ, яг тэр улсын тэр үйлдвэрийн эм орж ирлээ, тэр бөөний төв дээр ирлээ, тэр бөөний төвөөс, тэр эмийн сан руу явлаа, тийм жороор, тэр иргэнд очлоо гэдэг ингээд нэгдсэн тийм сүлжээтэй байх юм бол тэрүүгээрээ бид

нар бас хяналтаа сайн тавьчих боломжтой.

Энэ бол манай салбарт аягүй удаан жил яригдаж байгаа. Дээр нь одоо манайх бол бас гаалийн мэдээллийг бас давхар бид нар ингээд авдаг болох гээд гаальтай хамтраад явж байгаа. Тэгэхээр манайхаас лиценз авсан эм нь бид нар бүртгэлтэй чанартай гээд лицензээ өгчихлөө. Тэр нь ямархуу нөхцөлд тээвэрлэгдээд хил дээр ирээд, хилийн хяналтад ямар хяналтад ороод аль бөөний төвийн аль агуулах руу орчхов. Тэр агуулах дээр очоод ямар нөхцөлд байна вэ гэдэг юмаа бид нар ингээд 100 хувь яг одоо үнэнийг хэлэхэд бол Улаанбаатарт байгаа 1500 эмийн сан 200 хэдэн эмийн бөөний төв дээр яг улсын байцаагчийн хувьд бол зах вэ зах зээл дээр байгаа 10 байцаагч л байгаа. Яг эмийн зөвхөн эмийн байцаагч. Тэрний хувьд бол хүрэлцээ байхгүй.

Тийм учраас бид нар тэр цахимаараа хянадаг. Шаардлагатай юмаа яаралтай гялс түүвэрлээд дээжээ гялс гялс ингээд авчихдаг байхгүй бол 100 хувь бүх юмыг бид нар бас чадахгүй байгаа юм гэдэг асуудал.

Ж.Чинбүрэн: Шударга өрсөлдөөний газар. Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. 3 номерын микрофон.

Ц.Тэрбиш: Баярлалаа. Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя.

Энэ Монгол Улсын Шадар сайд эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар хяналт шалгалтыг 6 байгууллагад хийсэн. Манай байгууллагын хувьд яг үндсэн чиг үүргийнхээ хүрээнд энэ зах зээлд яг энэ эм, эмнэлгийн чиглэлийн бүтээгдэхүүнийг худалдан борлуулах энэ чиглэлийн зах зээлийг бид нар судалсан байгаа. Судлаад үзэхэд яг таны хэлдгээр зүй ёсны монопол, монопол байдалтай давамгайл байдалтай ААН-үүдийг хууль

тогтоомжид нийцүүлэн тогтоох шаардлага гарч байгаа. Энэ хамтарсан тушаалаар батлагдсан ажлын хэсгийн дүгнэлтийг үргэлжлүүлээд манай байгууллагаас үргэлжлүүлсэн шат дараатай ажлуудыг хийж байгаа. Хамгийн эхний ажлын үр дүн бол сая та бүхэнд маш товчхон танилцуулсан. Энэ Монос фарм, Ази фарм гээд яг энэ зах зээлийн чиглэл чиглэлийн давамгайл монопол энэ судалгааг хийгээд тогтоож байгаа юм. Энэ давамгайл монопол ААН-үүд тухайн яг энэ эм эмнэлгийн хэрэгслийн худалдан борлуулах, нийлүүлэх, энэ зах зээл дээр жижиг ААН-үүдийг тухайн энэ зах зээлээс шахан гаргах боогдуулах.

Дээр нь энэ иргэд хэрэглэгчдийн гар дээр ирж байгаа үнийг зохиомлоор нэмэгдүүлэх хэрэглэгчдийг хясан боогдуулах энэ бол үйлдлүүд тогтоогдож байгаа. Энэ үүднээс манай байгууллагын улсын байцаагчдын дүгнэлт гаргаж Монос фарм дээр эхнээс нь торгуулийн арга хэмжээ 8.4 тэрбумын төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан. Энийг системтэйгээр хяналт шалгалтаа өшөө нарийвчлан явуулах нь зүйтэй юм байна гээд Монгол Улсын Шадар сайдад бас төлөвлөгөөгөө гаргаад үргэлжлүүлээд хийгээд явж байна.

Ер нь бол гишүүд та бүхний хэлж байгаа бас зүй ёсны бол зүйл. Өрсөлдөөн байхгүйгээр энэ үнийн асуудал ярих өрсөлдөөн байхгүй газрын чанарын асуудал ярих нь өрөөсгөл асуудал. Бид нарын зүгээр энэ судалгааны дүнд энэ эм эмнэлгийн одоо энэ нийлүүлэлт энэ борлуулалтын энэ зах зээл өөрөө өрсөлдөөн нь хэт бөөгнөрсөн, хэт босоо болсон байгаа нь илт тодорхой байгаа юм.

Тэгэхээр энэ өрсөлдөөнийг л тэгш болгох байдлаас нь манай байгууллага ажиллаж байна.

Ж.Чинбүрэн: Баярлалаа. Сандаг-Очир гишүүн микрофоныг нээе.

Ц.Сандаг-Очир: Та нарын энэ дүгнэлтэд 4 дэх заалт дээр байгаа юм л даа. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5-д эм, эмнэлгийн хэрэгсэл, ханган нийлүүлэх байгууллага, иргэдэд эм, эмнэлгийн хэрэгсэл худалдахыг хориглохоор заасан. Гэтэл бодит бодит байдал дээр эмийн үйлдвэр эмийн импорт болон эм ханган нийлүүлэх тусгай зөвшөөрөл бүхий этгээдэд эмийн сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хамтад нь олгосноос ханган нийлүүлэх байгууллага хэрэглэгчдэд шууд үйлчилгээ үзүүлэх нөхцөл бүрдсэн.

Энэ шууд зөвшөөрлийг нь хэн өгдөг юм. Тэгээд эргүүлж хараад цаашид авах арга хэмжээн дээр нь юу байна вэ гэхээр энэ чиглэлээр тодорхой санал байхгүй байгаа байхгүй юу. Тэгэхээр нэг этгээд энэ зөвшөөрлийг өгч байгаа даа хамтад нь хууль дээрээ хориглочихсон байна шүү дээ. Эм ханган нийлүүлэх байгууллагууд эмийн сангийн үйл ажиллагаа. Гэх мэтчилнээс авхуулаад энэ чинь юу хэлээд байна вэ гэхээр ЭМЯ-ны харьяа энэ эмийн хяналт шалгалтын байгууллагууд чинь.

Ж.Чинбүрэн: Сандаг-Очир гишүүн дахин нэг минут өгье. Асуултаа гүйцээгээд асуучихъя.

Ц.Сандаг-Очир: Эндээс юу харагдаад байна вэ гэхээр энэ Эрүүл мэндийн яам холбогдох одоо яналт тавьж байх ёстой зөвшөөрөл өгдөг энэ байгууллагууд чинь өөрөө энэ эмийн байгууллагуудтайгаа хамаарал бүхий болчихсон явж байгааг л харуулаад байна шүү дээ. Зөвшөөрлөө өөрсдөө өгчихсөн байна шүү дээ. Зөвшөөрөл өгдөг төрийн байгууллага. Энэ чинь өөрөө эргээд монопол гэдэг юм уу тэр зах зээл дээр тийм байдлыг бий болгож, өрсөлдөөнийг

хязгаарлаж, үнэ хөөрөгдөх бас нэг шалтгаан нөхцөл нь байгаад байна шүү дээ. Тэгээд энэн дээрээ цаашидаа ямар арга хэмжээ авах юм. Эргээд харахаар ингээд цаашид авах арга хэмжээн дээр чинь ерөөсөө алга байна. Тодорхой заалт алга байна. Энийг юу гэж хэлэх юм. Сая эрх зүйн шинэчлэл хийх ёстой гээд байна.

Хуульд яг ямар эрх зүйн шинэчлэлийг хийлгэх гээд байгаа юм та.

Яг өнөөдрийн хуулиар аль заалт нь болохгүй байна аа? Энэ заалт гээд тодруул. Эрх зүйн шинэчлэл. Юм болохоор л хуулийг нь шинэчилнэ. Эрх зүйг шинэчилнэ гээд ингээд ярьдаг болчихож. Хуулиасаа болоод.

Ж.Чинбүрэн: Хариулт авах уу? 1 дүгээр микрофоныг нээе. Эрүүл мэндийн яам.

Оюунцэцэг ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын дарга.

П.Оюунцэцэг: Сандаг-Очир гишүүний асуултад хариулахаас гадна бусад зарим бас гишүүдийн асуусан асуултад зарим тодруулгыг нэмэлтээр өгөхийг хүсэж байна аа. Тэгэхээр одоо яг Эрүүл мэндийн яаман дээр Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын ажлын хэсэг явагдаад эхний төсөл ерөнхийдөө бол яамандаа нэлээн яригдаад 3 удаагийн удирдлагын зөвлөл, мэргэжлийн салбар зөвлөлүүдээр яригдсан хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудаа оруулаад бас хэлэлцүүлэг хийгээд ерөнхийдөө төсөл эцэслэж байгаа. Тэгэхээр энэ дээр бол бид тэр одоогийн байгаа эмийн хуулийгаа бид нар эм эмнэлгийн хэрэгслийн тухай хууль болгон бол өргөжүүлж байгаа. Эмнэлгийн хэрэгсэл буюу тоног төхөөрөмжүүдийг бид нар нэмэлтээр зохицуулахаар орж ирж байгаа юм хамтад нь. Эмийн чанар

анюулгүй байдлын талаар бид нар бүхэл бүтэн бүлэг оруулж ирж байгаа юм.

Тэгэхээр түрүүн гишүүдийн асууж байсан эмийн чанарын лабораторийн асуудал дээр бид нар эмийн чанарыг дан ганц лабораторийн арга биш дээрээс нь эрүүл мэндийн байгууллагууд болон иргэдийн дундах тандалт судалгааны аргыг бас нэмэлтээр оруулж ирж байгаа юм. Тэгэхээр түрүүн хэлсэн Батлут гишүүний асуултад санал дээр гарч байсан. Эрүүл мэндийн байгууллагууд дээр эмч нар өөрсдөө энэ эмийн чанарын асуудлыг ярьж байна гэдэг асуудал гарсан. Тэгэхээр бид нар Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль дээр эмийн чанарын талаар тандалт судалгааны нэг бүрэлдэхүүн хэсэг нь эрүүл мэндийн байгууллагуудаас тэр эмчилгээ үйлчилгээнд оролцож байгаа эмч нар сувилагч нар тандалт судалгааг авч байж лабораторитойгоо харьцуулах энэ аргыг хэрэглүүлэхээр хууль дээр шинэчилж оруулж ирж байгаа.

Хоёдугаарт нь эмийн чанарын лабораторийн асуудлаар бид нар 2024 оны төсөвт 5.5 тэрбумыг урьдчилсан байдлаар тусгасан боловч Сангийн яам энэ дээр бол энэ хасагдсан байгаа. Юутай холбоотой хасагдсан гэхээр Дэлхийн банкнаас бид нар бас энэ цар тахлын фанд гэсэн. Энэ төсөл дээр бид нар эмийн чанарын лабораторийг энэ чинь хүчин чадлыг бэхжүүлэх чиглэлээр төсөл бичээд дэмжигдсэн байгаа. 1.8 сая долларын төслийг бид нар эмийн чанарын лабораторийг сайжруулах чиглэлээр бас энэ санхүүжилтийг авахаар бол бас дэмжигдээд яг хариу нь ирчихсэн байгаа.

Тэгэхээр 2024 оны нэг сараас эхлээд бид нар энэ төсөл хэрэгжих үедээ эмийн чанарын лабораторийн асуудлыг бол бас нэлээн бэхжүүлэхээр оруулж ирж байгаа. Түрүүн тэр яасан нөлөөлж байгаа хүчин зүйлүүд яагаад ийм ялгаатай гарч байна вэ гэдэг асуудал дээр бид нар иргэдээс эмийн чанарын асуудлыг ямар байдлаар авахаар

зорьсон бэ гээд тэгэхээр чанаргүй байгаа гэж иргэдийн яриад байгаа шалтгаан нь юундаа байна вэ гэдгийг тодруулахаар авсан. Харьцангуй бас энэ дээр бол асуултуудаасаа шалтгаалсан уу? Зарим асуудлууд дээр бол бүрхэг асуудлууд ирсэн байх. Бүх асуулт бүрээрээ бол дахин эргэж задалж бол бас 2-оос 37 хувийн зөрөөний асуудлыг бид нар бас эргэж хянах үзэх шаардлагатай юм байна гэж бас ойлголоо.

Тэгэхээр энэ дээр бол бид нар зөрөөгөө бол тэр үед одоод эргэж гараад харъя гэж бодож байна. Эмийн чанар үнийн зохицуулалтын асуудал дээр бид нар бол үнийг чанартай нь хослуулан оруулахаар Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулга дээр оруулж байгаа. Эмийг бид нар сая Төрийн болон орон нутгийн бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай орон нутгийн нөгөө хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль дээр төр бол өөрөө эрүүл мэндийн байгууллагуудад хэрэглэгдэж байгаа эм, эмнэлгийн хэрэгслийг чанарын шаардлага хангасан гадаадын үйлдвэрлэгчээс болон ОУБ-аас шууд худалдан авах энэ зохицуулалтыг бол энэ хуульд хийж өгсөн байгаа. Тэгэхээр одоо төр өөрөө тэр хямд бөгөөд чанартай эмийг ОУБ-аас яаж худалдан авах журам дээрээ бид нар бас ОУБ-тай Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай, Санхүүгийн газартай, Сангийн яамтай ингээд ажлын хэсэг байгуулаад явж байна. Тэгэхээр эхний ээлждээ бид нар энэ эм ханган нийлүүлэх байгууллагуудаар худалдан авч байгаа энэ худалдан авах сонирхлыг нь төрүүлдэггүй хавдрын эмүүд байна.

Дээрээс нь энэ өнчин ховор тохиолддог өвчний үед хэрэглэдэг эмүүдийг олон улсын байгууллагуудаас бол худалдан авахаар энэ тооцоо судалгаа хийгээд явж байгаа.

Дараагийн ээлжид бол энэ бас яваандаа бол энэ иргэдийн дунд өргөн хэрэглээтэй байгаа өндөр үнэтэй эмүүдийг ч гэсэндээ ОУБ-аас харьцангуй бас хямд үнээр чанарын баталгаатайгаар авахаар энэ зохицуулалтуудыг бол бас хуульдаа тусгаад явж байгаа. Энэ мэдээллүүдийг нэмэлтээр өгье.

Ж.Чинбүрэн: Аанхан гол нэг чухал асуулт асуугаад байна шүү дээ. Энэ монопол тогтолцоог бий болгоход давуу боломж олгоод байгаа. Бөөнөөр худалддаг, үйлдвэрлэдэг хэр нь жижиглэнгийн худалдаа хийх зөвшөөрлийг хэн өгсөн юм гээд тодорхой асуулт асуулаа шүү. Нэг номер.

П.Оюунцэцэг: Энэ тусгай зөвшөөрлийн асуудлыг бол манай агентлаг бүрэн хариуцаж байгаа. Тэгэхээр энэ хууль дээр бол доогийн байдлаар бид нар Монос бол хамгийн их ханган нийлүүлэхүүд хийж байгаа. Дээшээ Монос бол 185 харьяа эмийн сантай байна гэсэн энэ судалгааны дүн гарсан байгаа. Эмийн сангуудын тусгай зөвшөөрлийг аваад үзэхээр Монос өөрөө охин компаниуд байгуулсан байдлаар яг Монос өөрийн биш Монос юу гэдэг юм Монос өөр байгууллагын нэртэйгээр.

Ж.Чинбүрэн: Зөвшөөрөл өгч байгаа тухай ярь даа тэгэхлээр цаг хугацаатай нь ярилаа. Аанхан сая бид бол 2020 оны эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн юун дээр агентлаг байгуулах тухай хууль орсон. 2021 онд байгуулагдсан. Энэнээс өмнөх гээд энэ он дараалалтай нь хэлчихье л дээ.

П.Оюунцэцэг: Өмнө нь агентлаг байгуулагдахаас өмнөх энэ тусгай зөвшөөрлийг бол ЭМЯ-ан дээр байгуулагдсан тусгай зөвшөөрлийн ажлын хэсэг олгож байсан. Агентлаг байгуулагдсанаас хойш бол энэ тусгай зөвшөөрлүүдийг олгоод явж байгаа. Одоо яг энэнтэй холбоотойгоор бид нар сая энэ хяналт шалгалтын үнэлгээний дүнгээс

өмнө бас Гааль татварын газартай хийсэн судалгааны дүнгээр ханган нийлүүлэхэд хоорондоо эм бас ингээд нөгөө зарж, борлуулдаг, солилцдог ийм дүр зураг бас харагдаж байсан. Тэгэхээр бид нар энэ дээр дүгнэлт хийгээд энэ маань бас үнийн өсөлтийн нэг шалтгаан болж байна гэж үзээд Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулга дээр ханган нийлүүлэхүй дотроо бол энэ эмийг хоорондоо солилцох худалдаалахыг хориглосон заалт оруулсан байгаа.

Дээрээс нь энэ ханган нийлүүлэхүйд бас эмийн сангийн үйл ажиллагааны зөвшөөрөл эрх авах эрхийг нь бол бид нар юу яасан, хориглосон заалтаар оруулсан. Ажлын хэсэг дээр бол энэ дээр бас нэлээн бодолцохгүй бол одоогийн байгаа энэ зах зээл дэх энэ эмийн сангуудаа яах вэ гэдэг асуудлыг хөндөж тавьсан байгаа.

Тэгэхээр энэ яг заалт бол түр түдгэлзчихсэн заалттай явж байгаа.

Ж.Чинбүрэн: Сандагаа гишүүн хангалттай юу хариулт.

Би бас нэг хэдэн зүйл тодруулж бас дүгнэж хэлье гэж бодож байна.

Ямар ч байсан ингээд Шадар сайдын алба, ЭМЯ-тай хамтраад эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, зохистой хэрэглээний өнөөгийн байдалд хийсэн хяналт, шалгалт, үнэлгээний дүнг сонслоо. Энд бас манай түр хорооны хянан шалгагч нар сууж байгаа. Та бүхэн мэдээлэл авч байгаа байх. Энэтэй холбоотой энэ судалгаатай холбоотой, энэ тайланттай холбоотой нэмэлт мэдээллүүдээ та бүхэн шууд энэ судалгаа хийсэн 6 байгууллагын хүмүүстээ шууд асуултаа тавьж жишээлбэл асуумжууд нь бүүр дотроо тийм яаж асуусан байна гэдгийг бас анхаарч лавлаж тодруулаарай. Миний зүгээс харж байгаа зүйл ямар ч байсан нэг судалгаагаа хийгээд та бүхэн нэг богино

хугацаанд Монгол Улсын эмийн зах зээл монополдсон байна гэдгийг нотолсон байна.

Хоёрт үнийн өсөлт гааль дээр ирж байгаа мэдүүлэг иргэдийн гар дээр очиж байгаа эм 1.1-1.3 дахин дунджаар шүү дээ. Зарим эм нь бүүр 2-оос 3 дахин нэмэгдсэн байх жишээтэй гэдгийг дүгнэсэн байна. Бас нэг чухал зүйлийг бас энд дурдсанд би бас баяртай байгаа зүйл энэ эксклусив гэрээ. Энэ Эксклусив гэрээ гэдгээр дамжуулаад Монголын зах зээл дээр өрсөлдөгчгүй үнээ тогтоох боломжийг олгож байгаа энэ том асуудал шүү дээ. Тэгэхлээр энийг хэн олгодог юм ЭМЯ олгож байсан шүү.

Би өөрөө эмнэлгийн дарга ч хийж байсан, эмч ч хийж байсан. Зах зээл дээр 100 долларын үнэтэй эмийг Монголд оруулж ирээд 500 доллар зараад байгаа шүү дээ. Энэ чинь жинхэнэ шулалт байхгүй юу. Тэгээд тендерээр дамжуулж энэ эмийн өсөлтийг хиймлээр бий болгож байгаа асар том луйвар энд явж байгаа. Эксклусив асуудал дээр манай хянан шалгагч нар бас онцгой анхаарах хэрэгтэй. Энэ бол дистрибьютер шинээ хийхдээ эксклусив авчихдаг. Тэгээд Монголын зах зээл дээр өөр хүн оруулахгүй байх энэ хорио хязгаарыг тавьчихдаг. Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн газрынханд би бас талархаж байна. Энэ дээр бас оролцоотой ажиллаж энэ торгуулийн тэр санкц тавьсан байна. Гэхдээ биелэлт нь байгаа юу. Одоо жишээлбэл Монос фарм гэдэгт 8.4 тэрбум төгрөгийн торгууль тавьсан байна. Энийгээ авч чадсан уу? Ингээд гүйцэтгэл их чухал.

Дээрээс нь манай ажлын гишүүд бас хэлж байна. Энэ ард иргэд энэ эмийн борлуулалт эмийн худалдан авалттайгаа холбоотой сэтгэл ханамж байхгүй гэдгийг та бүхэн бүр батлаад олон дахин батлаад гаргаад өглөө. Бид санхүүгийн дэмжлэгийг нь нэмээд байдаг, ард иргэдийн карман

дээр санхүүгийн ачаалал өгөхийг багасгаад хорин долоохон тэрбум төгрөгийн зайлиггүй шаардлагатай эмийн хөнгөлөлт байсныг өнөөдөр 140 тэрбум болгочоод байж байна шүү дээ. Тэгээд энэ үргэлжлээд л байх юм бол энэ бид нарын тавьсан төсөв ард иргэдийн хөнгөлөлт биш эсрэгээр хэдэн компаниудыг дэмждэг өөшүүлдэг ийм тогтолцоо руу бид орох гээд байгаа учраас яаралтай бид энэ түр хороо байгуулж ажиллаж байгаа нь өөрөө зөв байна гэдгийг баталж байгаа бас нэг том ажил боллоо гэж харж байна.

Тэгээд мэдээлэл тайлан сонслоо.

Бид нарын хийх ажил бас цаашаа юу юун дээр чиглэх ёстой гэдэг юмэн дээр бас тайлан, мэдээлэл өгч байгаа гэж бас харж байгаа. Тэгээд хэдүүлээ бас үргэлжлүүлээд энэ хурлаа үргэлжлүүлье.

Тэгээд мэдээлэл өгсөн, тайлан өгсөн та бүхэнд баярлалаа.

Харин нэг бас онцолж хэлэх зүйл бол манай энэ төрийн тогтолцоонд бид эмийн зохицуулалтын агентлаг байгуулдгийн гол зорилго бол энэ зах зээлийг хяналттай байлгая гэж зориод байгаа шүү дээ. Эмийн худалдааг хяналттай төрийн оролцоотой хийе гэж хүсээд байгаа. Гэхдээ бид хувийн хэвшлийнхний бизнесийг хорьж хумих ийм зорилго тавиагүй тийм ээ. Төрөөс худалдан авалт хийж байгаа зайлиггүй шаардлагатай эмийгээ бид хянадаг байя. Ер нь Монголын зах зээл дээр эмийн худалдаагаа чанартай хянадаг ийм тогтолцоо руу шилжих ийм том зорилго тавьж байгаа юм.

Тэгэхээр эмийн агентлаг одоо хүртэл түр орлон гүйцэтгэгчтэй сууж байна. Батлут гишүүн ээ? Тийм ээ, одоо жинхэнэ гүйцэтгэгч байхгүй. Ийм байж байна. Тэгэхлээр одоо бид энэ улам цаашаа сайжруулах, чанаржуулах зах зээлээ

хянадаг тогтолцоо та нарын Энхтуяа дарга аа таны үүрэг болчихоод байгаа шүү дээ.

Тийм учраас зөвшөөрөл өгсөн бол буцаагаад зөвшөөрөл авч чаддаг байх хэрэгтэй шүү дээ. Энэ дээр онцгой анхаарах ёстой. Хөнгөлөлт үзүүлж байгаа бол тэр хөнгөлөлт нь ард иргэдийн карман дээр ачаалал болж очдог биш, та бүгдийн судалгаан дээр энэ 100 төгрөгийн үнэтэй эм 200 төгрөг болоод очиж байна шүү дээ. Энэ дундаа татварын дарамтууд НӨАТ-ын дарамтууд энэ чинь буцаад иргэний карман дээр л очиж байгаа. НӨАТ гэдэг бол ерөөсөө л иргэний карман дээр очиж байгаа л дарамт шүү дээ тийм ээ. Харин ийм зүйлүүд байна. Ингээд үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгье.

Батлут гишүүн үг хэлэх юм байна. Батлут гишүүний микрофоныг нээе.

Д.Батлут: Монгол Улс чөлөөт зах зээлийн системд ороод 30 гаран жил болчихож байна. Тэгээд чөлөөт зах зээлийн системд орсон болохлоор л уул нь тийм иргэддээ ээлтэй тогтолцоо, иргэддээ ээлтэй үйлчилгээ, иргэддээ ээлтэй тийм чанар бүхий л зүйл явах ёстой, үнэ бүхий л зүйл явах ёстой л доо.

Харамсалтай нь өнгөрсөн энэ 30 жилийн хугацаанд тийм зүйлийг хийж чадаагүй байна. Үндсэндээ бол нэг зарим нэг ААН-үүдийг монопол үйл ажиллагаатай болгоход төр туслалцсан тийм нөхцөл байдлууд үүссэн байна. Саяын тайлан дээр гарлаа Сандаг-Очир гишүүн асуугаад байна шүү дээ.

Монос гэж компанид яагаад жижиглэнгийн худалдаа эрхлэх зөвшөөрлийг олгочихсон юм бэ гээд. Бөөний үйл ажиллагаа явуулдаг тэгээд хөдөө орон нутагт байдаг тэр аптекууд, бөөний төв нь, жижиглэнгийн үнүүд нь ямар байдгийг та бүхэн бас очиж үзээрэй.

Тэндээс том дүгнэлт хийх боломжтой. Тэгээд юу гэж харж байгаа вэ гэхээр ингээд нэг чөлөөт зах зээлийн нийгэмд шилжиж орчихсон гэсэн мөртөө ингээд нэг монопол болгоход төр оролцоод явчих юм бол хамгийн том аюул болно шүү.

Монголчууд нэг ярьдаг даа гичий чонотой нийлсэн Монгол банхар ямар их аюул тарьдаг гэж ярьдаг. Яг тэрэн шиг л болно шүү нөхөд өө. Тийм учраас бид нар энэ асуудлууд дээрээ цэгцэлж янзалж авах зайлигүй шаардлага байгаа. Мэдээж бид нар зөв онош тавьж байж зөв үр дүнгүүд гарах асуудлуудаа гаргаж тавьж шийдэх ёстой гэж харж байгаа.

Эрүүл мэндийн асуудал Монгол Улсын 3 сая гаруй иргэн бүрд хамааралтай асуудал. Энэ эмийн асуудал, эмийн чанарын асуудал, үнийн асуудал. Тийм учраас одоо энэ асуудал бол Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд ч хамаарахаар асуудал гэж ойлгож байгаа шүү. Тодорхой хэмжээний төрийн зохицуулалт байх ёстой гэж үзэж байгаа миний хувьд. Магадгүй тэр маркетингийн түвшинд нь төр оролцдог юм уу гээд. Уул нь энэ агентлаг байгуулагдсан гээд байгаа тийм ажил хийх ёстой л гэж би хардаг. Өнөөдөр тэгээд юу хийж байгаагаа ч мэдэхгүй л хүмүүс сууж байх шиг байна. Дарга цэрэг ч байхгүй. Тэгэхээр бид нар юун дээр нэг онцгой анхаарч энэ Түр хорооноос тодорхой зөвлөмж чиглэлүүд гарах хэрэгтэй. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн асуудал ямар байр суурьтай оролцох юм.

Дээрээс нь энэ төрийн оролцоо энэ эрүүл мэндийн салбар, тухайлбал эмч, эмнэлгийн хэрэгсэл дээр, энэ салбар дээр ямар оролцоотой байх вэ гэдгийг ингээд тодорхойлж, гаргаж, загварчлалаа боловсруулах ёстой гэж үзэж байгаа юм. Ингэж байж бид нар харьцангуй тийм зөв шийдлүүдийг гаргаж авна аа. Тэрэн шиг тэгэхээс биш өнөөдрийн ингээд тайлан

ярьж байгаа юм шиг болохгүй л бол тийм хууль болохгүй байна, ийм хууль болохгүй байна гээд ярьчихдаг. Тэгээд нэг жижигүүрийн үгсээ цэнэглэж ярьсаар байгаад 4 минутаа дуусгачихдаг. Ийм ажлын хэсэг энэ тэр байх юм бол бидний энэ Түр хорооны ажлын үр дүн гарахгүй ээ, гарахгүй. Та нар зүгээр одоо энэ дүнгийнхээ танилцуулгыг үзээд хараарай.

Хөөрхийс гэмээр л юм харагдаж байна шүү дээ. Яг үнэндээ би хоёрхон зүйл л асуусан. Энийг чинь хүмүүс учир мэддэг хүмүүс уншаад үзэх юм бол шоолно шүү нөхөд өө. Арга барилаа өөрчилмөөр байгаа юм, нөхөд өө. Магадгүй энэ ААН-үүд чинь 2 баланстай болчихсон байгаа. Та нарт хэлдэг нэг үнэ нь нэг өөр, иргэдэд зардаг нэг үнэ нь нэг өөр гээд л зөндөө асуудлууд байгаа байхгүй юу. Тэр бүхэн дээр та нар анализ хийж чадахгүй л явж байна шүү дээ. Үгүй үндсэн үйл ажиллагаан дээр анализ хийж чадахгүй ч байгаа юм чинь яаж тэр зүйл дээр анализ хийх вэ дээ бас тэгээд. Байдаг шүү дээ. Намайг Засаг даргаар ажиллаж байхад нэг махны үнэ нэмэгдлээ л гэсэн. Манай төрийн байгууллагынхан очиж үзчихээд нэмэгдээгүй байна гэж орж ирсэн. Тэр төрийн байгууллагын дарга нарыг танихгүй хүн ч гэж юу байх вэ. Очингуут нэг сайхан үнэ бичээгүй байж байгаад л ингэж зарж байгаа гээд сайхан үнээ хэлчихдэг. Гараад өөр иргэн ороод ирэнгүүт нь нөгөө нэмэгдсэн үнээ хэлчээж л байгаа байхгүй юу.

Ажил амьдралын зөрөө гэдэг чинь энэ байхгүй юу даа. Энэ бүх зүйлийг бид нар бодож боловсруулж энэ зүйлүүдийг хаасан тодорхой асуудлуудыг гаргаж тавьж байж бид нар зөв онош, зөв шийдлүүдийг гаргах ёстой шүү гэдгийг хэлмээр байна аа.

Баярлалаа.

Ж.Чинбүрэн: Баярлалаа.

Сандаг-Очир гишүүн үг хэлнэ. Тэр миний асуусан асуултад тойрч хариулаад байна. Би тодорхой эзэнтэй юм яриад байгаа байхгүй юу. Хэн гэдэг даргын хэзээний тушаал шийдвэрээр энэ эрх олгогдоод байгаа юм. Тусгай зөвшөөрөл олгогдоод байгаа энэ тэр гээд ярихаар тойруулж яриад ингээд, нэгт.

Хоёрт би энэ асуудлаараа одоо яг ингээд хянан шалгалт хийсний энэ дүгнэлт танилцуулгаар ингээд асуудлыг бариад явах арай хангалтгүй л юм шиг санагдаж байна.

Дараагийн ээлжид би хяналт шалгалт хянан шалгах, манай хороо, түр хороо, бас нэг нийтийн сонсгол хиймээр юм шиг санагдаж байна Чинбүрэн дарга нийтийн сонсгол хийж. Нийтийн сонсголыг маш үр дүнтэй хиймээр байна. Хянан шалгагч нарын үнэлгээ дүгнэлт бодитой байх. Яг энэ Монгол Улсад борлуулагдаж байгаа импортоор орж ирж байгаа хэрэгжисж байгаа эм хэрэгслийн өнөөгийн бодит байдал эмийн өсөлтөд нөлөөлж байгаа юм юу байна. Чанарын хувьд ямар байгаа юм гээд. Эндээс бид нар ААН-үүдээ бас монопол гээд хэт бас ингээд байж болохгүй шүү дээ бас. Зах зээл өрсөлдөөний нийгэмд зах зээлд бас хий хэн хийж чадаж байна гэдэг нь тэр ААН-үүд томорсноороо үнэхээр цаана нь тэр оруулж ирж байгаа бараа бүтээгдэхүүн нь чанартай байна уу гэдгийг л улсын төсөвт төвлөрүүлэх орлого юмаа үнэхээр ил тод бүрдүүлж байна уу, үгүй юу гэдэг үнэхээр шаардлага хангасан энэ эмийг оруулж ирж байна уу үгүй юу?

Үнэхээр тэр хууль эрхийн зөвшөөрөл нь хууль зүйн хүрээнд олгогдсон уу, үгүй юу гээд. Тэгээд бас энэ салбарт оруулж ирж байгаа үйл ажиллагаа явуулж байгаа энэ томоохон компаниудаа бас чичилж болохгүй. Чичилж болохгүй. Монопол

нэрийн доор бас л энэ чинь ард иргэдийн эрүүл мэндийн асуудлыг тодорхой хэмжээнд сайн муугаар хэлүүлэн барин авч явж байгаа юм. Гагцхүү бид нар энэ одоо хянан шалгалтын ажлын хүрээнд хууль, эрх зүйн хүрээнд яг ямар ямар асуудлууд авах юм гэдгээ маш тодорхой болгомоор байна. Яг аль хуульд, аль хуулийн аль заалт тодорхойгүй байгаад байгаа юм. Хэнд ямар давуу байдал бий болгоод байгаа юм гэдгийг маш тодорхой болгож өгмөөр байна. Ингэж байж Улсын Их Хурал дээр яригдана, тогтоол чинь.

Хоёрт хил гаалийн хүрээнд ямар татвар тийм үү зохицуулалтууд нь ямар хэмжэ 17 хувийн өсөлт гараад байна шүү дээ тээвэр. Хил гаалийн НӨАТ-аас авхуулаад. Энэ дээр ямар зохицуулалт хийлгэмээр байгаа юм. Хиймээр байгаа юм.

Өөр татвар, зээлийн бодлогоор түрүүн бас ганц нэг дурдсан байна. Энэ чиглэлийн үйл ажиллагааг эрхэлдэг компаниудад зээлийн, хөнгөлөлттэй зээлийн асуудлууд хүртэл ярьсан байна. Өшөө лабораторийнхоо асуудлыг Засгийн газарт үнэхээр үндэсний аюулгүй байдал, хүн амын ард иргэдийн эрүүл мэндийн асуудал яригдаж байгаа бол энийг хийх ёстой л гэж үзэж байгаа бол одоогийн байгаа лабораторийг яаж орчин үеийн болгох юм. Түүнд шаардлагатай байгаа хөрөнгө оруулалтыг ирэх жил яаж одоо хэнд чиглэл болгож шийд гэж чиглэл өгөх юм тогтоолоор.

Эрүүл мэндийн яам, хяналтын байгууллагууд маань энэ дээр яг ямар арга хэмжээ авах юм. Эмийн хяналт шалгалтын ерөнхий газар өөрөө яг ямар арга хэмжээ авах юм. Энэ тусгай зөвшөөрлүүд дээр ямар өөрчлөлт хийх юм. Ингээд цаашид авах арга хэмжээнүүд чинь яг маш үг өгүүлбэрээрээ тодорхой байж байж Улсын Их Хурлын тогтоол болж гарна шүү. Тогтоол болж гарна шүү.

Энийг хийхийн тулд та бүхний хийсэн хяналт шинжилгээний энэ дүгнэлтүүд суурь болно. Тооцоо судалгаа чинь хэрэг болно. Ийм ийм байгаа учраас ийм арга хэмжээ авах шаардлагатай байна гэдэг юмыг ярина. Энэ нь өөрөө мэргэжлийн байгууллагуудын тооцоо судалгаан дээр гарсан юм гэдгийг ингээж ярина. Тийм учраас хяналт шалгалтын ажлын хэсгийнхэн маань ингээд ажлаа дуусчихлаа гэж болохгүй. Хянан шалгагч нар маань энэ шалгалтын мөрөөр хийгдсэн энэ үнэлгээ дүгнэлтийг бас эргээж харна. Бодит байдалтай нийцэж байгаа нийцэхгүйг нь тодорхой болгоно. Тэгээд хэдүүлээ энэ нэг асуудлын нэг ард гарч чадах нь уу, үгүй юу?

Энэ бүрэн эрхийн хугацаа гэдэг юм уу, энэ намрын чуулганы хугацаанд гэдэг юм уу нэг жоохон ахиц өөрчлөлт гаргачихвал бас мөн ч их хэрэгтэй байна даа. Ард иргэдэд. Энэ нүүрснээс чинь илүү энэ асуудал шүү. Хүн болгонд нүүрсний асуудал.

Ж.Чинбүрэн: Сандаг-Очир гишүүнд баярлалаа. Чухал манай хянан шалгагч нар энэ саяын хэлж байгаа зүйлүүдийг анхааралдаа авна. Тэгэхээр энэ тайлангаа танилцуулсан Эрүүл мэндийн яам, Эм эмнэлгийн хэрэгслийг хянан зохицуулах газар, Шударга өрсөлдөөн та бүгдийн энэ богино хугацаанд хийсэн энэ судалгаа энэ тайлан бид нарын ажилд бас нэлээн том түлхэц өгч байгаа. Үүнтэй тодруулах зүйлүүдээ дахин хэлэхэд манай хянан шалгагч нар сайн тодруулж мэдээлэл авна.

Тэгээд манайх түр хорооноос гарах энэ тогтоол бол Засгийн газарт дүгнэгдэх тогтоол бол ЭМЯ-нд энэ Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хуулиа хурдан боловсруулах монопол тогтолцоог үгүй болгох заалтууд заавал байх ёстой. Түрүүн Оюунцэцэг дарга хэллээ бид гагцхисан байгаа гэж. Тэгж болохгүй шүү дээ. Тийм нөлөөнд автаж тэр заалтаа оруулж чадахгүй гагцхисан гэж юу байсан юм.

Би өөрөө ажлын хэсгийн Эмийн хуулийн ажлын хэсгийг ахалж байсан. Бүтэн 8 сар наад хууль дээр чинь ажиллаад та нар буцааж өгсөн шүү дээ. Тэгээд тэрэн дээр ганц заасан заалт бол бөөний худалдаа эрхэлж байгаа бол 5-аас ихгүй, жижиглэнгийн худалдааны юутай байх ч гэдэг юм уу ийм зохицуулалтууд байгаа шүү дээ. Тэр саналуудыг хэлж байсан. Тэгэхээр бид бас энэ монопол тогтолцоо олигополийн тогтолцоог устгахад шударга өрсөлдөөний газар та бүхэн бас энд саналаа оруулж өгөөрэй. Манай шинжээч нар Шударга өрсөлдөөний газартай уулзаж энэ чиглэлээр бас мэдээллүүд авах ёстой. Ингээд та бүгдийн тайланг сонслоо.

Баярлалаа.

Одоо бид дараагийн хурлаа үргэлжлүүлэн та бүхэн хүрэлцэн ирсэнд баярлалаа.

Дараагийн хэлэлцэх асуудал руугаа оръё оо.

Хоёр дахь хэлэлцэх асуудал.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5-д хянан шалгагч нь Түр хорооны өмнө ажлаа хариуцах бөгөөд олон нийтэд зориулсан мэдээлэл хийхгүй. Мөн хуулийн 57 дугаар зүйлийн 57.3-д хянан шалгагчийн ажлын хөлс болон тусгай шалгалттай холбоотой зардал, нөхөн төлбөр, ажлын хөлсний хэмжээг Түр хороо тогтооно гэж заасны дагуу Түр хорооны дотоод асуудлыг хэлэлцэх учраас хаалттай хуралдах горимын саналыг гаргаж байна аа.

Хаалттай хуралдаанд шилжүүлэх саналыг дэмжиж байгаа гишүүдийн саналыг авъя.

Санал санал хураалт.

*Хаалттай горимд шилжье гэдэг
санал хураалт дэмжиж байгаа нь.
Гишүүдийн 80 хувийн дэмжлэгтэй хурал
хаалттай горимд шилжиж байна.*

12:30 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН:ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА

Түр хорооны хуралдааны тэмдэглэл
2023 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 15-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ